



**SGP** The GEF  
Small Grants  
Programme

**25**  
YEARS



Empowered lives.  
Resilient nations.

*Дэлхийн цараагаар сэтгэж  
Нутгийн энгээр бүтээцгээе*

# БАЙГАЛЬ ОРЧНОО ХАМГААЛАХАД ХАМТДАА

ДАЯН ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ САНГИЙН ЖИЖИГ ТӨСЛИЙН ХӨТӨЛБӨРӨӨС  
2003-2014 ОНУУДАД МОНГОЛ УЛСАД ЯВУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Улаанбаатар хот  
2018 он

# БАЙГАЛЬ ОРЧНОО ХАМГААЛАХАД ХАМТДАА

ДАЯН ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ОРНЫ САНГИЙН ЖИЖИГ ТӨСЛИЙН ХӨТӨЛБӨРӨӨС  
2003-2014 ОНУУДАД МОНГОЛ УЛСАД ЯВУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн Жижиг Төслийн Хөтөлбөрийн санхүүжилтээр  
“Жимсний Эх Цэцэрлэг” төрийн бус байгууллагаас бэлтгэн хэвлүүлэв.

Хянасан: Б. Ганбаатар, *Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн Жижиг Төслийн  
Хөтөлбөрийн Үндэсний Зохицуулагч*

## АГУУЛГА

Товчилсон үгсийн жагсаалт .....	3
Өмнөтгөл .....	4
Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн Жижиг Төслийн Хөтөлбөрийн тухай .....	5
Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн Жижиг Төслийн Хөтөлбөрөөс 2003-2014 онуудад хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тухай .....	5
Нэг. Суулгац үржүүлэх, мод тарих .....	7
Хоёр. Нөхөрлөлийн болон ТББ-ын эзэмшлийн жимсний цэцэрлэгүүд .....	9
Гурав. Иргэд, нөхөрлөлийн зөгийн аж ахуй .....	10
Дөрөв. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал .....	12
Тав. Хамтын оролцоотой ойн менежмент .....	14
Зургаа. Экосистем болон элэгдсэн газрын нөхөн сэргээлт .....	17
Долоо. Орон нутагт хэрэглэгдэх арга техникүүд .....	18
Найм. Загас хамгаалал .....	20
Ес. Ховор болон эмийн ургамлыг тарималжуулах .....	22
Арав. Шахмал түлш .....	24
Арван нэг. Нөхөрлөл, иргэдийн эзэмшлийн усан толио .....	26
Арван хоёр. Нөхөрлөлийг чадавхижуулах .....	27
Арван гурав. Иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, орлогыг нэмэгдүүлэх .....	29
Зарим тэргүүний нөхөрлөлийн ахлагчдын ажлын амжилт, туршлагаас .....	31
Ажлын төлөө төрсөн хүн .....	31
Сэргээхээр шийдсэн гэр бүл .....	31
Ажилсаг гэр бүл .....	32
Хөдөлмөрийг амталж чадсан эрхэмтэй хийсэн товч ярилцлага .....	33
“Хөгжилд Хүрэх Түншлэл” төрийн бус байгууллагыг танилцуулах нь .....	34
Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн Жижиг Төслийн Хөтөлбөрийн фото цомгоос .....	37

## ТОВЧИЛСОН ҮГСҮЙН ЖАГСААЛТ

БОНХЯ	Байгаль орчин ногоон хөгжлийн яам
ДДБОС	Даян Дэлхийн Байгаль Орчны Сан
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
ЖТХ	Жижиг Төслийн Хөтөлбөр
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НИТАЖ	Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал
ОХУ	Оросын Холбооны Улс
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ТББ	Төрийн бус байгууллага

## ӨМНӨТГӨЛ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс хэрэгжүүлдэг Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн Жижиг Төслийн Хөтөлбөр нь 2003 оноос Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хөдөөгийн иргэдийн ахуй, амьжиргааг дэмжих, тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх чиглэлээр ажиллаж 2014 оны эцэс гэхэд нийт 382 жижиг төслийг орон нутгийн байгаль хамгаалах нөхөрлөлүүд, малчдын бүлгүүд, хоршоод, байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн байна.

Монгол улс зах зээлийн харилцаанд шилжээд удаагүй, улс орны эдийн засагт болон иргэдийн амьдралд хүндхэн жилүүд үргэлжилж байсан тэр үед энэхүү Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн нь зөвхөн байгаль орчны төдийгүй иргэдийн нийгэм, ахуй, амьдралын олон асуудлуудыг хамтатган авч үзэж шийдвэрлэхэд ихээхэн тус дэм болсон гэж уг Хөтөлбөрийн Үндэсний Зохицуулагчийн хувьд үздэг юм. Хувийн өмчийг зөвшөөрдөггүй, улс нийгмийн гэгдэх аж ахуй бүхий өмнөх нийгмийн харилцаанд дассан иргэд, хөдөлмөрчид зах зээлийн харилцаанд шилжихэд тун амаргүй байсан нь мэдээж. Шинэ тутам байгуулагдсан хамтын оролцоотой ойн менежментийн болон байгаль хамгаалах нөхөрлөлүүд хөдөөгийн иргэдийг байгаль орчныг хамгаалах чиглэлээр төрөл бүрийн арга ажиллагаанууд тэдгээрийн дотор суулгац үржүүлэх, мод тарих, зөгий маллах гэх мэт олон чухал ажлуудад сургаж дадлагажуулах, ялангуяа нөхөрлөлүүдийг чадавхижуулахад багагүй цаг хугацаа, хөрөнгө хүч зарсныг энд тэмдэглэмээр байна.

Энэхүү Хөтөлбөр Монголд анх үйл ажиллагаагаа эхэлж байхад иргэд, нөхөрлөлүүд зөвхөн мод тарих, үржүүлэх ажлыг хийж эхэлж байсан бол өнөөдөр нөхөрлөлийн, иргэдийн эзэмшлийн жимсний цэцэрлэгүүдийг олноор байгуулж, өөрсдийн жимсний хэрэгцээгээ хангаад зогсохгүй, бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлдэг боллоо өсөж дэвжсэнийг харахад таатай байна. Зөгийн аж ахуй сүйрлийн байдалд байсан бол өнөөдөр зөгий болон зөгийчдийн

тоо өмнөх үеийнхээс хол давжээ. Жижиг Төслийн Хөтөлбөрт хамрагдагсад анх төслөө хэрэгжүүлэхдээ бие даан ажлаа эхэлж давхар суралцаж байсан бол өнөөдөр хамтын оролцоотой ойн менежмент, иргэдийн хамгаалалттай газар, иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал, зөгий маллагаа, загас хамгаалал зэрэг олон чиглэлээр өөрсдийн хэмжээнд бүтээн байгуулалт хийж цаашид зохистой менежмент хийх, ирээдүйн хөгжлийг төлөвлөх шатандаа хэдийнээ орсон байна. Энд тэмдэглүүштэй бас нэг зүйл бол манай Хөтөлбөрт хамрагдаад өөр өөрсдийн орчинд тус тусынхаа үйл ажиллагааг явуулдаг нөхөрлөл, бүлэг, хоршоо, төрийн бус байгууллагууд нэгдэн бие биенээ дэмжиж туршлагаа хуваалцан хамтын хөдөлмөр дээр тулгуурласан байгалийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, амьжиргаагаа дээшлүүлэх, дотоод гадаадын зах зээлд нэвтрэх, хамтдаа хөгжих зорилгоор “Хөгжилд Хүрэх Түншлэл” нэртэй төрийн бус байгууллагыг 2013 онд байгуулан ажиллуулж байгаа нь тэдэнд цаашид олон боломжуудыг авчрана гэдэгт эргэлзэхгүй байна.

Тус Хөтөлбөрийн зүгээс дээрхи хугацаанд хамтран ажилласан бүх байгууллагууд, иргэддээ гүн талархал илэрхийлэхийн ялдамд дан ганц буюу салангид төслүүдэд суурилсан үйл ажиллагаагаа 2015 оноос эхлэн аажмаар зогсоож ландшафтын түвшинд зохицуулалттай нэгдмэл үйл ажиллагаа явуулж буйгаа мэдэгдэж төвийн бүсийн иргэд, нөхөрлөлүүд, төрийн бус байгууллагуудыг хамтран ажиллахыг урьж байна.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай!

**Хөтөлбөрийн Үндэсний Зохицуулагч Б.Ганбаатар**

Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн Жижиг Төслийн Хөтөлбөрийн тухай

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)-өөс хэрэгжүүлдэг Даян Дэлхийн Байгаль Орчны Сан (ДДБОС)-гийн Жижиг Төслийн Хөтөлбөр (ЖТХ) нь “Дэлхийн цараагаар сэтгэж нутгийн энгээр бүтээцгээе” гэсэн уриан дор байгаль орчныг хамгаалах, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхээр дэлхийн 10 гаруй оронд 1992 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ. Өнгөрсөн хугацаанд уг Хөтөлбөр дэлхийн 130 гаруй орныг хамарч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хөдөө орон нутгийн иргэдийн ахуй, амьжиргааг дэмжихтэй уялдуулсан жижиг төслүүдэд санхүүгийн болон техникийн дэмжлэг туслалцаа үзүүлдэг дэлхийн хэмжээний томоохон хөтөлбөр болон өргөжсөн байна.

Хамтын оролцоо, ардчилал, уян хатан болон ил тод байдал нь ЖТХ-ийн дөрвөн тулгуур зарчим юм. Энэхүү Хөтөлбөр нь нөхөрлөлийн гишүүд, орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагууд, хөдөөгийн иргэдэд түшиглэсэн байгууллагууд болон бусад сонирхогч талуудыг хөтөлбөр, түүний үйл ажиллагааны төлөвлөлт, боловсруулалт, хэрэгжилтэд өргөнөөр оролцуулахыг зорьдог юм. Төслүүд нь жижиг ч үзүүлэх нөлөө нь их байдгаараа онцлогтой. ДДБОС-гийн ЖТХ 2003 оноос Монголд үйл ажиллагаагаа эхлэн явуулж Архангай, Баянхонгор, Булган, Дархан-Уул, Дундговь, Говьсүмбэр, Орхон, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Өвөрхангай гэсэн 11 аймгийн нутаг дэвсгэрт жижиг төсөл хэрэгжүүлж иржээ. *Зураг 1.*


ЖТХ-ийн үндсэн зорилго нь биологийн төрөл зүйлийг хамгаалах, уур амьсгалийн өөрчлөлтийг сааруулах, олон улсын усыг хамгаалах, газрын элэгдэл эвдрэл, цөлжилттэй тэмцэх, удаан задардаг органик бохирдуулагч бодисуудыг хэрэглээнээс гаргахад чиглэсэн үйл ажиллагааг хөдөөгийн иргэд, нөхөрлөлүүд, байгаль орчны төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхэд оршдог. Уг Хөтөлбөрөөс хэрэгжүүлж байгаа төслүүд нь бусад газруудад давтагдах боломжтой, асуудлыг шинэлэг аргаар оновчтой шийдсэн, аливаа шийдлийг биет байдлаар гарган үзүүлж бодит үр дүнг эрхэмлэсэн, хөдөөгийн иргэдийн нийгэм-эдийн засаг, байгаль орчны нөхцлийг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулах үйл ажиллагаанд чиглэдэг юм.



Зураг 1. ДДБОС-гийн ЖТХ-т хамрагдсан нутаг дэвсгэрийн хилийн зураг

Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн Жижиг Төслийн Хөтөлбөрөөс 2003-2014 онуудад хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тухай

Д Д Б О С - г и й н ЖТХ нь 2003 оноос байгаль орчныг хамгаалах, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр Монгол улсад үйл ажиллагаагаа эхэлж 2014 оныг дуустал хугацаанд 340 гаруй нөхөрлөл, малчдын бүлэг, төрийн бус байгууллагуудтай хамтран нийт 382 жижиг төсөл хэрэгжүүлсэн



Зураг 2. 2003-2014 онуудад ДДБОС-аас хийсэн санхүүжилтийн хуваарилалт (арга хэмжээний төрлүүдээр)

байна. Эдгээр төслүүдэд ДДБОС-гаас 2,804,579 америк долларын санхүүжилт зарцуулсан бөгөөд нэг төсөлд дунджаар 7,342 америк доллар ногдож байна. Хэрэгжүүлсэн нийт төслийн санхүүжилтийн 52 хувийг биологийн төрөл зүйлийг хамгаалахад, 29 хувийг газрын элэгдэл, эвдрэлтэй тэмцэхэд, 9 хувийг уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад, тус бүр 1 хувийг олон улсын усыг хамгаалах болон удаан задардаг органик бохирдуулагчдыг хэрэглээнээс гаргахад чиглэсэн арга хэмжээнд, үлдэх 8 хувийг холимог үйл ажиллагааг санхүүжүүлэхэд тус тус зарцуулсан байна. *Зураг 2.*

ЖТХ-өөс дээрхи төслүүдийг хэрэгжүүлэх явцад 838,262 америк доллартай тэнцэх мөнгөн хөрөнгийг, 1,942,747 америк доллартай тэнцэх мөнгөн бус хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч талуудаас хамтарсан санхүүжилт хэлбэрээр, 194,906 америк долларыг бусад хандивлагчдаас тус тус төвлөрүүлж чадсанаар 382 жижиг төсөл нийтдээ 5,780,494 америк долларын өртөгтэй болжээ. *Зураг 3.*



*Зураг 3. 2003-2014 онуудад хийсэн төслийн санхүүжилтийн хуваарилалт (эх үүсвэрүүдээр)*

ДДБОС-гийн ЖТХ-өөс 2003-2014 онуудад орон нутгийн байгаль хамгаалах нөхөрлөлүүд, малчдын бүлгүүд, хоршоод, байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус

байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн 382 жижиг төслийн үйл ажиллагааг судалсны үндсэн дээр зонхилох 13 чиглэлийн үйл ажиллагааг сонгон авч чиглэл тус бүрээр хийгдсэн ажил, арга хэмжээ болоод гарсан үр дүнг тоймлон бэлтгэж бусад сонирхогч нөхөрлөл, бүлэг, байгууллага, иргэдэд танилцуулах, нөгөө талаар ДДБОС-гийн ЖТХ 2015 оноос эхлэн ландшафтын түвшинд ажиллахаар болсон тул энэ үеийг хүртэл хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнг нэгтгэн дүгнэх нь зүйтэй гэж үзсэн байна.

2003-2014 онуудад ДДБОС-гийн ЖТХ-өөс хэрэгжүүлсэн төслүүдийн зонхилох 13 чиглэлийг дараах байдлаар тогтоов. Үүнд:

1. Суулгац үржүүлэх, мод тарих
2. Нөхөрлөлийн болон ТББ-ын эзэмшлийн жимсний цэцэрлэгүүд
3. Иргэд, нөхөрлөлийн зөгийн аж ахуй
4. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал
5. Хамтын оролцоотой ойн менежмент
6. Экосистем болон элэгдсэн газрын нөхөн сэргээлт
7. Орон нутагт хэрэглэгдэх арга техникүүд
8. Загас хамгаалал
9. Ховор болон эмийн ургамлыг тарималжуулах
10. Шахмал түлш
11. Нөхөрлөл, иргэдийн эзэмшлийн усан толио
12. Нөхөрлөлийг чадавхижуулах
13. Иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, орлогыг нэмэгдүүлэх

Хөтөлбөрийн үйл ажиллагааны энэхүү тоймыг бичихдээ асар түргэн хурдацтай хөгжлийн энэ эринд нийгэм зав чөлөөгүй болж бидний ном, хэвлэл унших цаг хомсдож байгааг харгалзан аль болох товч бөгөөд тодорхой бичиж фото зургууд түлхүү оруулж өгсөн болно.

## Нэг. СУУЛГАЦ ҮРЖҮҮЛЭХ, МОД ТАРИХ

**Нөхөрлөл, ТББ-уудын ойжуулах, мод тарих ажилд дэмжлэг үзүүлэх нь**

Мод дагаж ус, ус дагаж амьдрал гэсэн үг бий. Ой мод нь хуурай газрын бүх амьтан ургамлын 80 орчим хувийнх нь амьдрах орчин болдгийн зэрэгцээ усыг хуримтлуулан барих, жигд хуваарилах замаар байгалийн усны горимыг зохицуулж байдгаараа онцгой ач холбогдолтой, байгалийн үнэт баялаг юм. Мод бол хүчилтөрөгч үйлдвэрлээд зогсохгүй агаарын бохирдлыг бууруулдаг хамгийн чухал байгалийн шүүлтүүр юм.

Манай улсад ойг нөхөн сэргээх, шинээр ойжуулалт хийх, хот, суурин газруудад мод, бут, сөөг тарих, тариалангийн талбайд ой зурвас байгуулах гэх мэт нийгэм, ахуй, эдийн засгийн төрөл бүрийн хэрэгцээнд зориулан мод үржүүлэх ажлыг олон арван жилийн өмнөөс улсын өмчийн ойн мэргэжлийн байгууллагууд хийж байсан боловч улс орон зах зээлд шилжиж эхэлсэн үеийн эдийн засгийн гүн гүнзгий хямралын улмаас энэ ажил тодорхой хугацаанд ихээхэн хумигдсан байдаг. Улс орон зах зээлийн харилцаанд шилжих үйл явц өрнөхийн хэрээр хувийн хэвшлийн аж ахуйнууд олноор бий болж байсан хэдий ч ой модыг ашиглах тал нь нэг хэсэгтээ давамгайлж мод үржүүлгийн ажил хоцрогдонгуй явж байсан билээ. Харин 2000-гаад оны эхэн үеэс ой болон байгаль хамгаалах чиглэлийн нөхөрлөлүүд олноор байгуулагдаж эхэлсэнтэй уялдан суулгац үржүүлэх, мод тарих, ойжуулах ажлын цар хүрээ аажмаар тэлж ахиц дэвшил гарч эхэлсэн ерөнхий дүр зураг харагддаг. ДДБОС-гийн ЖТХ нь 2003 оноос Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн нь олон нөхөрлөл, төрийн бус байгууллагууд болон иргэдийг суулгац үржүүлэх, мод тарих ажилдаа дэмжлэг авах, энэ чиглэлээр мэргэших, үйл ажиллагаагаа өргөжүүлэх сайхан боломжийг нээж өгсөн байна.

Сайн чанарын суулгац үржүүлэхэд чанартай үр хэрэгтэй болдог тул байгалийн мод, бутлаг ургамлын үр түүж бэлтгэдэг иргэд,

нөхөрлөлийн тоо жилээс жилд нэмэгдэж байна. Энэ нь манай орны уур амьсгалд зохицсон мод, бутыг тарьж ургуулан нөөцийг нь нэмэгдүүлэхэд онцгой ач холбогдолтой ажил билээ.

**Хэрэгжүүлсэн төслийн тоо:** 63

**Хамарсан нутаг дэвсгэр:** Архангай, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Орхон, Өвөрхангай, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын зарим сумд

**ЖТХ-ийн санхүүжилт:** 425,410 ам.доллар

**Төсөл хэрэгжүүлсэн нөхөрлөлийн тоо:** 28

**Төсөл хэрэгжүүлсэн төрийн бус байгууллагын тоо:** 35

**Төсөл хэрэгжүүлэгчдээс гаргасан хөрөнгө:**

**-мөнгөн:** 180,766 ам. доллар

**-материаллаг:** 300,066 ам. доллар

**Бусад хандивлагчийн санхүүжилт:** 3,000 ам. доллар

**Үр ашиг хүртэгсдийн тоо:** 6000

**Үндсэн зорилтууд:** Зах зээлийн харилцаанд шилжих үеийн эдийн засгийн гүнзгий хямралын дараахан олноор байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн хамтын менежментийн ойн нөхөрлөлүүд болон хөдөөгийн иргэдийг төрөл бүрийн модны суулгац үржүүлэх, мод тарих ажилд сургаж дадлагажуулах, өмнөх нийгмийн үед ажиллаж байгаад дампуурсан улсын өмчийн мод үржүүлгийн газруудыг орлох нөхөрлөлийн болоод хувийн эзэмшлийн мод, суулгац үржүүлгийн газруудыг олноор байгуулахад дэмжлэг үзүүлэх явдал хэрэгжүүлсэн төслүүдийн үндсэн зорилт байсан байна.

**Үйл ажиллагааны тойм:** Суулгац үржүүлэх, мод тарих чиглэлээр явуулсан үйл ажиллагааг дотор нь мод, бутлаг ургамлын үр түүх, үрийн нөөц бүрдүүлэх, үрээр суулгац үржүүлэх, модлог эсвэл ногоон мөчрөөр ил талбайд эсвэл хүлэмжинд суулгац үржүүлэх гэж хуваан авч үзэж болохоор байна.

Эрүүл, зөв өсөлттэй тарьц, суулгац бойжуулах, сайн чанартай өндөр бүтээмжтэй ой бий болгох үндсэн нөхцөл нь мод үржүүлэг, ойжуулалтын ажилд удамшлын сайн чанар бүхий үрийг сонгож тарих явдал тул үр бэлтгэх талбайг сонгож авах, үр түүх арга техник эзэмших,

үрийн чанарыг тодорхойлох, үрийг технологийн дагуу зөв хадгалах, тариалалтад бэлтгэх, ариутгах зэрэг асуудлуудаар хэд хэдэн удаагийн сургалт явуулж иргэд, нөхөрлөлийн гишүүдийг сургаж дадлагажуулах ажлыг зохион байгуулсан байна. Мөн үрээр ил талбайд суулгац үржүүлэхийн тулд талбайг сонгож авах, хөрсийг боловсруулах, үр суулгах, соёололтыг түргэсгэх, тарилтын дараах арчилгаа, усалгаа хийх, суулгацыг хадгалах, ойжуулалт болон талбайн тарилтад бэлтгэх олон сургалтуудыг шат дараатай зохион байгуулж ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлийн гишүүд, иргэдийг олноор оролцуулсан байна. Сургалтанд хамрагдсан олон тооны нөхөрлөлүүдийг суулгац үржүүлэх, ойжуулах, талбайд мод тарих ажилд оролцуулахаар жижиг төслүүд хэрэгжүүлж суулгац үржүүлэх, мод тарих талбайн хашааны тор, шон, хадаас, усалгааны жижиг систем, усны шахуурга, шланк зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжүүдээр хангаж, талбай боловсруулах болон дизель түлшний зардлыг нь тооцож олгосны дээр 60 гаруй нөхөрлөлийг суулгац үржүүлэхэд нь зориулж хүлэмжтэй болгожээ. Мөн үржүүлсэн суулгацыг талбайн цэцэрлэгжилт, хот суурин газруудад ногоон байгууламж бий болгох, орон нутагт ойжуулалт, нөхөн сэргээлт хийх, зах зээлд борлуулах, салхины хамгаалалтын зурвас байгуулах зэрэгт ашиглахад зориулсан дэмжлэг туслалцаануудыг тухай бүрд нь үзүүлсээр ирсэн байна.



Шинэс модны үрийг түүн хатааж байгаа нь

Үхрийн нүд, чацаргана, тэхийн шээг зэрэг хэд хэдэн төрлийн жимсний модыг модлог мөчир болон ногоон мөчрөөр үржүүлэх ажлыг нэлээд өргөн хүрээнд зохион байгуулж арга техникийг нь олон иргэдэд эзэмшүүлжээ. Мөн улиас, бургасыг модлог мөчрөөр үржүүлэх, хайлаас, голт бор, шинэс, нарс,

долоогоно, бүйлээс, гүйлс, шар хуайс, мойл, интоор, өрөл, харгана, тавилгана, агч, гандигар, жигд зэрэг модыг үрээр нь үржүүлэх ажлыг гүйцэтгэх олон жижиг төслүүдийг хэрэгжүүлсэн байна.

**Үр дүнгийн тойм:** Тус хөтөлбөр 2003-2014 онуудад суулгац үржүүлэх, мод тарих ажлыг дэмжихэд чиглэсэн жижиг төслүүдийг төвийн бүсийн 11 аймгийн нутаг дэвсгэрт хөдөөгийн иргэдийн нөхөрлөлүүд, малчдын бүлгүүд болон төрийн бус байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлсний үр дүнд 230 гаруй нөхөрлөл, орон нутгийн төрийн бус байгууллагууд мод үржүүлэх, тарих ажилд шинээр суралцан идэвхитэй хамтран ажиллаж ирсний дээр тэдний жишээ, туршлагаар олон арван нөхөрлөл, иргэд энэ ажлыг сонирхон өөрсдийн хүчээр хийж гүйцэтгэх болжээ. Энэ ажлыг дагнан эрхэлж байгаа нэг нөхөрлөл, иргэн дунджаар 3 мянган суулгац үржүүлэн гаргаж байгаа бөгөөд зарим сайн ажиллагаатай нөхөрлөл, төрийн бус байгууллагууд жилд 80 мянга хүртэл тооны суулгац үйлдвэрлэн гаргаж байсан тоо баримт байна.

ЖТХ-өөс ойн нөхөрлөлүүдийг мод, бутлаг ургамлын сайн чанарын үр түүж бэлтгэн технологийн дагуу хадгалах арга ажиллагаанд сургах чиглэлээр 3 жижиг төсөл хэрэгжүүлсэн бөгөөд тухайн төсөл хэрэгжүүлсэн жилүүддээ төрөл бүрийн гоёл чимэглэл, жимсний болон бусад модны үрийг 400 кг хүртэл хэмжээгээр түүж дараа хавар нь үрслүүлэн суулгац бэлдэж байсан байна. Олон нөхөрлөл үр түүж бэлтгэх дадал, туршлагатай болж мод, бут, байгалийн ургамлын үр бэлтгэгчдийн бүлэг, сүлжээ бий болох боломж бүрджээ.

Иргэд, нөхөрлөлүүдийг модны суулгацыг үр болон ургал эрхтнээр нь үржүүлэх ажилд сургаж дадлагажуулахад багагүй цаг хугацаа, хөрөнгө, хүч зарснаар 130 орчим нөхөрлөл энэ ажлыг чанартай хийж чаддаг болсон байна.

Хэрэгжсэн нийт төслийн 70 орчим хувьд нь мод тарих ажлыг ямар нэг хэмжээгээр оруулж иргэдийн сэтгэхүйд нөлөөлөх, энэ ажлын ач холбогдлыг нийгэмд таниулахыг зорьж ажилласнаар төсөлд хамрагдсан бараг бүх нөхөрлөл, төрийн бус байгууллагууд мод тарих ажил, арга барилд сайн суралцаж мод, бутлаг ургамлаас байгаль болон нийгэмд үзүүлэх нөлөө, ач холбогдлыг сайтар ойлгож мод, ургамалд элэгтэй буюу тэдний заримынх нь хэлдгээр модны “хобби”-той болжээ.

## Хоёр. НӨХӨРЛӨЛИЙН БОЛОН ТББ-ЫН ЭЗЭМШЛИЙН ЖИМСНИЙ ЦЭЦЭРЛЭГҮҮД

### Нөхөрлөл, төрийн бус байгууллагын эзэмшлийн жимсний цэцэрлэгүүд бий болгох нь

Манай ард түмэн жимсний аж ахуйг дээр үеэс уламжлан эрхэлж байгаагүй ч байгалийн зэрлэг жимсийг түүж хүнсэндээ хэрэглэсээр иржээ. Манай улс 1950-иад эхлэн орон нутагт жимсний аж ахуйг хөгжүүлэх алхмуудыг хийж хэд хэдэн газарт жимс, ногооны эрдэм шинжилгээний станцуудыг байгуулан ажиллуулж, зарим нэгдэл, сангийн аж ахуйнууд жимс жимсгэнэ тариалж нийтдээ 1000 орчим га талбайгаас зарим төрлийн жимс хураадаг байжээ. Гэвч улс орон зах зээлийн эдийн засагт шилжих үеийн эдийн засгийн хямралаас шалтгаалан жимсний аж ахуй бүхэлдээ уналтад орж жимс тариалалт эрс хумигдсан байдаг. Гэсэн ч удалгүй иргэд болон ойн нөхөрлөлүүдээс жимсний суулгац үржүүлэх, жимсний мод тарих санаачлагууд гарч ажил хэрэг болон өрнөжээ. Энэ үеэс эхлэн ДДБОС-гийн ЖТХ эдгээр санаачлагуудыг дэмжин нөхөрлөлийн эзэмшлийн жимсний цэцэрлэгүүдийг олноор байгуулахад нь тусалж дэмжсээр иржээ. Иргэд, нөхөрлөлүүд өөрийн эзэмшлийн жимсний цэцэрлэгтэй болсноор амин дэмийнхээ хэрэгцээг хажуу дэргэдэх хашаанаас хангах болж тэр хэмжээгээр эзгүй ууланд зэрлэг жимс түүхээр явж байгаль сүйтгэдэг иргэдийн тоо ч эрс буурахад нөлөөлөх ирээдүйтэй.

**Хэрэгжүүлсэн төслийн тоо:** 47

**Хамарсан нутаг дэвсгэр:** Архангай, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Орхон, Өвөрхангай, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын зарим сумд

**ЖТХ-ийн санхүүжилт:** 311,645 ам.доллар

**Төсөл хэрэгжүүлсэн нөхөрлөлийн тоо:** 26

**Төсөл хэрэгжүүлсэн төрийн бус байгууллагын тоо:** 21

**Төсөл хэрэгжүүлэгчдээс гаргасан хөрөнгө:**

**-мөнгөн:** 146,325 ам. доллар

**-материаллаг:** 204,707 ам. доллар

**Бусад хандивлагчийн санхүүжилт:** 5,146 ам. доллар

**Үр ашиг хүртэгсдийн тоо:** 5000

**Ерөнхий зорилтууд:** Энэ чиглэлээр хэрэгжсэн төслүүдийн ерөнхий зорилтууд нь иргэд, ойн нөхөрлөлүүдийг жимсний модны суулгац үржүүлж сургах, өрхийн жимсний аж ахуй эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх, иргэд, нөхөрлөлийн эзэмшлийн жимсний жижиг цэцэрлэгүүд байгуулж өөрсдийн жимсний хэрэгцээгээ хангахад дэмжлэг үзүүлэх, түүнчлэн хэрэгцээнээс илүү гарах жимсээ зах зээлд нийлүүлэх, жимсээр төрөл бүрийн хүнсний бүтээгдэхүүн хийх арга ажиллагаанд сургахад чиглэжээ.

**Үйл ажиллагааны тойм:** Нөхөрлөлийн болон ТББ-ын эзэмшлийн жимсний аж ахуйг хөгжүүлэх, жимст цэцэрлэгүүд байгуулах ажлын хүрээнд нийт 100 гаруй мянган чацарганы, 60 гаруй мянган үхрийн нүдний суулгацыг иргэд нөхөрлөлүүдэд нийлүүлж тариулсан дүнтэй байна. Мөн тэхийн шээг, интоор, бөөрөлзгөнө зэрэг жимсний суулгацыг зарим иргэд, нөхөрлөлүүдэд нийлүүлж тариулжээ. Жимсний цэцэрлэгийг хашиж хамгаалах зайлшгүй шаардлагатай байсан тул хашааны тор, шон зэргийг суулгацуудын хамт төсөлд хамрагдсан нөхөрлөл бүрт нийлүүлсний дээр усалгаа хийхэд зориулж усны шахуурга, резин хоолойгоор хангасан байна. Мөн зарим төслийн төсөвт худаг гаргаж өгөх, дуслын усалгааны тоног төхөөрөмж авах зардлыг тусгаж хэрэгжүүлжээ.

Сэлэнгэ аймгийн Баянгол сумыг тусгайлан сонгон авч түүний “Ногоон Сум” Хөтөлбөрийн хүрээнд айл өрхүүд, албан газруудад 2 жилийн хугацаанд 6000 гаруй жимсний мод хуваарилан тариулснаар олон айл өрхүүд хашаандаа жимсний модтой болсон байна.

Жимсний аж ахуйг хөгжүүлэх, ялангуяа үржүүлгийн ажлыг явуулахад эх цэцэрлэг байгуулах явдал чухал ач холбогдолтой тул хэд хэдэн газар эх цэцэрлэг байгуулах төслүүдийг санхүүжүүлжээ.

Мөн өөр нэг чухал ажил бол иргэдийн жимсний аж ахуйг хөгжүүлэх арга замууд, ач холбогдол, ашиг тусын талаархи мэдээллийг олон нийтэд хүргэх, ойлгуулах талаар хөдөө орон нутагт олон жилийн турш өргөн хүрээнд явуулсан мэдээлэл, суртчилгаа, сургалтын дэс дараатай арга хэмжээнүүд юм.

**Үр дүнгийн тойм:** Хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнд ТББ болон нөхөрлөлийн эзэмшил бүхий жимсний 26 цэцэрлэг говь, хээр, хангайн бүсэд байгуулагдан тэдний нийгмийн амьдрал, ахуйд чухал үүрэг гүйцэтгэх болжээ. Эдгээр цэцэрлэгүүдэд тухайн үед олноо сайтай байсан чацаргана, үхрийн нүдийг голчлон тарьж ургуулсан бол тэхийн шээг, интоор, бөөрөлзгөнө, тошлой, өрөл, монос зэрэг жимсний моднуудыг олдох хэмжээгээр нь тарьсан байна.



Багануурын орчимд “Хөх Монгол чацаргана” нөхөрлөлийн байгуулсан жимсний цэцэрлэг

Д э э р х и цэцэрлэгүүд нь талбайн хэмжээгээр харилцан адилгүй тул зарим нөхөрлөл гишүүдийнхээ өрхийн жилийн хэрэгцээний жимсийг бэлтгэж байгаа бол зарим ТББ, нөхөрлөлүүд 5 хүртэл тонн чацаргана хураан авч зах зээлд шууд нийлүүлэх

эсвэл төрөл бүрийн бүтээгдэхүүн хийж зарах, өрхийн хэрэгцээгээ хангах зэргээр ашиглаж байгаа сайхан жишээнүүд олон байна.

Нөхөрлөлийн болон ТББ-ын эзэмшлийн жимсний цэцэрлэгийг манай оронд урьд өмнө байгаагүй, шинэ байгууламж гэж үзэж болох талтай. Нөгөө талаар шинэ ойлголт ч гэж үзэж болохоор байгаа юм. Ийм цэцэрлэгүүдийг байгуулж авснаараа нөхөрлөл, ТББ-ууд өөрийн гэсэн нэг төрлийн өмчтэй болохын зэрэгцээ нийгмийн, эрүүл мэндийн, аж ахуйн гээд маш олон талын ашиг хүртэх боломжтой болсон байна. Нөхөрлөлийн цэцэрлэг нөхөрлөлийг олон талаар хөгжүүлдэг гэж үздэг. Иймд нөхөрлөлийн цэцэрлэгээс нөхөрлөлийн хөгжилд оруулах хувь нэмрийг энэ төслүүд хэрэгжсэний хамгийн чухал ач холбогдол, үр дүн гэж үзэхээр байна.

Гурав. ИРГЭД, НӨХӨРЛӨЛИЙН ЗӨГИЙН АЖ АХУЙ

### **Байгалийг нөхөн сэргээгч, эмчлэгч, хүнс үйлдвэрлэгч зөгийг маллах арга, ажиллагааг ойн нөхөрлөлүүдэд эзэмшүүлэх нь**

Зөгийн аж ахуй нь хүний биед зайлшгүй хэрэгцээт аминдэм, биологийн идэвхт бодисоор баялаг хүнсний чухал бүтээгдэхүүн болох зөгийн бал, зөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг төдийгүй хүний ямар нэгэн оролцоогүйгээр экосистемийг бүрдүүлж, байгалийн экологийн нөхцлийг тогтворжуулагч, байгаль орчинд хамгийн эерэг нөлөө бүхий хөдөө аж ахуйн салбар юм. Монгол оронд анх 1959 онд 20 бүл зөгийг тухайн үеийн ЗХУ-ын Буриад улсаас Сэлэнгэ аймгийн Шаамарын жимс жимсгэний эрдэм шинжилгээний станцад авчирснаар зөгийн аж ахуйн эх суурийг тавьсан гэж ярьдаг. Үүнээс хойш балт зөгийг манай орны ойт хээрийн бүс нутгийн Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дорнод, Архангай, Булган, Завхан, Увс, Ховд зэрэг аймгуудад үржүүлэх болсон байна. Манай орны ихэнх нутагт балт ургамлын нөөц сайтайгаас зөгий үржүүлж өндөр ашигтай салбар болгон хөгжүүлэх ирээдүйтэй юм. Эрдэмтэн Г.Очирбатын судалгаагаар манай оронд 2 сая орчим зөгийн бүл үржүүлж жил бүр дунджаар 22,000 тонн хэрэгцээний бал авч ашиглах боломжтой аж.

Зөгийн аж ахуйгаас бал, лав, тоосормог, сүүнцэр, жилий, хор, уурагт бодис гэх мэт олон тооны бүтээгдэхүүнийг авч хүнс, эмчилгээ, гоо сайхны болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг. Зөгийн бал нь хүний урт наслах, эрүүл байхын нэг үндэс болдог гадна ургамлын тоос хүртэлтийг ихээхэн нэмэгдүүлдгээрээ ургамлын аймагт таатай нөлөө үзүүлж мал аж ахуй, газар тариалан зэрэг хөдөө аж ахуйн салбар төдийгүй биологийн олон төрөл зүйлд үр ашгаа өгдөг байна. Бэлчээрийн талхагдал, хомсдол, цөлжилт зэрэг хүндрэл, бэрхшээл тулгарч буй өнөө үед энэ нь туйлын ач холбогдолтой.

Улс орон зах зээлд шилжих үед манай оронд шинэ тутам хөгжиж байсан зөгийн аж ахуй тухайн үеийн социалит аж ахуйн

бусад салбарын нэгэн адил уналтанд орж тоо толгой нь ихээхэн хорогдсон бөгөөд мэргэжлийн зөгийчдийн гар дээр очсон цөөн тооны зөгийн бүлүүд л зах зээлийн шилжилтийн хүнд үеийг давсан байдаг. 1959 оноос хойшхи 30 жилийн хугацаанд 20 бүлээс 4768 бүл хүртлээ өссөн зөгийн аж ахуй зах зээлийн шуурганд өртсөнийхөө дараа дахин сэргэж 2015 оны статистак тоогоор 10138 бүлд хүрсэн байна.

**Хэрэгжүүлсэн төслийн тоо:** 18

**Хамарсан нутаг дэвсгэр:** Архангай, Дархан-Уул, Орхон, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын зарим сумд

**ЖТХ-ийн санхүүжилт:** 166,279 ам. доллар

**Төсөл хэрэгжүүлсэн нөхөрлөлийн тоо:** 11

**Төсөл хэрэгжүүлсэн төрийн бус байгууллагын тоо:** 7

**Төсөл хэрэгжүүлэгчдээс гаргасан хөрөнгө:**

-мөнгөн: 34,172 ам. доллар

-материаллаг: 84,467 ам. доллар

**Бусад хандивлагчийн санхүүжилт:** 10,000 ам. доллар

**Үр ашиг хүртэгсдийн тоо:** 600

**Үндсэн зорилтууд:** Архангай, Дархан-Уул, Орхон, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын нутаг дэвсгэрт өмнө нь зөгий маллаж байсан болон шинээр зөгийн маллах хүсэл, сонирхолтой иргэд нөхөрлөлүүдийг зөгийжүүлэх, зөгийн бүлийн тоо толгой болон бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг нэмэгдүүлэх, зөгийг байгаль, экологийн нөхцлийг тогтворжуулах, нөхөн сэргээх, хөдөө аж ахуйн таримал ургамлуудын ургац, гарц болон үр өгөөжийг нэмэгдүүлэхэд ашиглах, зөгийчдийн орлого, ахуй амьдралыг сайжруулахад төслүүдийн үндсэн зорилтууд чиглэсэн байна.

**Үйл ажиллагааны тойм:** Зөгийн аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн 18 төслийн хүрээнд иргэд, нөхөрлөлийн гишүүдийг зөгий маллах сургалтад хамруулах, харилцан туршлага судлуулах, зөгийн бүл худалдан авч өгөх, эх зөгий гарган авах, зөгийн зохиомол хээлтүүлгийн багаж нийлүүлэх, орон нутагт зөгийчдийн уулзалт зөвлөгөөн зохион байгуулах, талбайн сургалт явуулах, Дархан-

Уул аймгийн Орхон сумын Зөгийчдийн холбоонд үйл ажиллагаагаа явуулах ажлын байр барьж өгөх, Батсүмбэр суманд зөгийн өвөлжөө барих, зөгийн үүр хайрцаг, бал ялгагч гэх мэт хэрэглээний тоног төхөөрөмж болон зөгийн өвчинтэй тэмцэх эм хэрэгслээр хангах, ОХУ-аас шинэ хүчтэй зөгийн сүрэг оруулж ирэн сэлбэлт хийх, зөгийчдийн дундын цөм сүрэг бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг шат дараалан хэрэгжүүлсэн байна.

**Үр дүнгийн тойм:** Нийт 200 гаруй зөгийчид, зөгий сонирхогч иргэд болон байгаль хамгаалах нөхөрлөлүүдийг танхимын болон талбайн сургалтууд, туршлага солилцох уулзалтууд болон танилцах аялалуудад хамруулж зөгий маллах арга ажиллагаанд сурган мэдлэгийг нь дээшлүүлж, өөр хооронд нь танилцуулж харилцан мэдээ, мэдээлэл солилцох боломжтой болгосон байна. Өмнө нь зөгий маллаж байгаад зөгийгүй болсон болон шинээр зөгий маллах сонирхолтой байгаль хамгаалах нөхөрлөлүүдийг төлөөлөн сургалтанд хамрагдагсан 32 зөгийчинд тодорхой тооны зөгийн бүлийг дотоодоосоо болон ОХУ-



Орхон аймгийн “Цөм сүрэг” зөгийчдийн бүлэг

аас авч нийлүүлснээр зах зээлд шилжих үеийн эдийн засгийн хямралд өртөн уналтанд ороод байсан зөгийн аж ахуйн сэргэлтэд ихээхэн хувь нэмэр оруулсан байна.

Зөгийчдийн зохион байгуулалт, удирдлага, менежментийг сайжруулах үүднээс зарим сум, орон нутгийн зөгийчдийн холбоодуудыг офисын байртай болгох, шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, эм, ариутгалын бодисоор хангах, зөгийн үүр хайрцаг үйлдвэрлэх ажлуудад тодорхой дэмжлэг туслалцаа үзүүлсээр ирсэн нь олон зөгийчдийн талархлыг хүлээсэн байна.

Эх зөгий гаргаж авах байрыг Орхон суманд барьж зөгийд зохиомол хээлтүүлэг хийх багажийг Дархан-Уул аймгийн Дархан сумын туршлагатай зөгийчинд нийлүүлснээр зөгий хэлтүүлгийн ажлыг орчин үеийн багаж төхөөрмжөөр гүйцэтгэх дадлага, туршлага эзэмших боломжийг бүрдүүлж өгчээ.

## Дөрөв. НУТГИЙН ИРГЭДЭД ТҮШИГЛЭСЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

### **Байгаль орчинд хамгийн ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь**

Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал (НИТАЖ) нь шинэ зүйл огт биш бөгөөд харин ч аялал жуулчлалын хамгийн анхны хэлбэрүүдийн нэг гэдгээрээ байгаль орчинд хамгийн ойр, хамгийн ээлтэй аялал жуулчлалын хэлбэр юм. Бөөнөөр эсвэл хэсэг бүлгээр орчин үеийн машин, техник хөлөглөн онгон зэрлэг байгальд аялах нь мэдээж биологийн төрөл зүйлд сөрөг нөлөөтэй. Гэтэл НИТАЖ бол байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөө үзүүлэх учиртайгаас гадна тухайн газрынхаа ард иргэдийн нийгэм, соёл, ахуйн талаар жуулчдад тодорхой мэдлэг авах илүү боломжийг олгохоос гадна гүнзгий сэтгэгдэл ч үлдээж чадна. Байгаль хамгаалах эртний асар баялаг уламжлал, ёс заншилтай манай орны хувьд НИТАЖ нь эдгээр уламжлал, ёс заншлыг хадгалан үлдэх, дэлхийн бусад орны иргэдэд сурталчлах, хотол олноороо хотжих үйл явцад өртөөд байгаа хойч үеийнхэндээ таниулж мэдүүлэхэд онцгой ач холбогдолтой юм. НИТАЖ малчид иргэдийн өдөр тутмын амьдралтай холбоотойгоор хамт явагдаж байдгаараа онцлогтой, зардал чирэгдэл багатайгаараа бусад төрлийн аялал жуулчлалын өмнө маш давуу талтай гэж хэлж болохоор бөгөөд цаашдын хөгжил нь нутгийн иргэдийн өөрсдийнх нь идэвхи, чармайлтаас ихээхэн хамааралтай. Өнгөрсөн хугацаанд хөдөөгийн нөхөрлөлүүд, иргэд, малчдад маань жуулчдыг хүлээн авч байрлуулах оромжийн асуудал хамгийн хүнд байсан бол өнөөдөр аялал жуулчлалын бүтээгдэхүүн дээр илүү анхаарах цаг нь болжээ. ЖТХ-өөс ч цаашид энэ тал дээр үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэх нь чухал байна.

**Хэрэгжүүлсэн төслийн тоо:** 16

**Хамарсан нутаг дэвсгэр:** Архангай, Булган, Дундговь, Өвөрхангай, Төв, Хэнтий, Говь-Алтай аймгуудын зарим сумд

**ЖТХ-ийн санхүүжилт:** 110,812 ам. доллар

**Төсөл хэрэгжүүлсэн нөхөрлөлийн тоо:** 9

**Төсөл хэрэгжүүлсэн төрийн бус байгууллагын тоо:** 7

**Төсөл хэрэгжүүлэгчдээс гаргасан хөрөнгө:**

-**мөнгөн:** 37,961 ам. доллар

-**материаллаг:** 98,658 ам. доллар

**Үр ашиг хүртэгсдийн тоо:** 500

**Үндсэн зорилт:** Тодорхой газар нутаг, байгалийн өвөрмөц тогтоц, ан амьтан, ургамал, жигүүртэн шувууд, нуур, рашаан ус зэргийг байгаль хамгаалах нөхөрлөлдүүд, хэсэг бүлэг иргэд сайн дурын үндсэн дээр хамгаалах үйл ажиллагаа явуулж түүндээ түшиглэн нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хөгжүүлж ахуй нөхцөл, орлогоо нэмэгдүүлэх санал, санаачлагыг дэмжихэд хэрэгжсэн төслүүдийн үндсэн зорилт оршиж байна.

**Үйл ажиллагааны тойм:** Төв аймгийн Баяндэлгэр сумын Гүн галуутай, Архангай аймгийн Тариат сумын Тэрхийн цагаан нуур, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Хятрууны рашаан, Хустын рашаан, Зүүнбаян-Улаан сумын Чинмэнд хоршоо, Арвайхээр сумын Цагаан бургас, Есөн зүйл сумын Баян Дөлгөөн Хайрхан, Хэнтий аймгийн Дадал сумын Балжийн гол, Балжийн тохой, Говь-Алтай аймгийн Цогт сумын Ээж Хайрхан гэсэн газруудад зэрлэг амьтад, нуур, рашаан ус, шувуу, байгалийн үзэсгэлэнт тогтоц зэргийг орон нутгийн захиргаатай тохиролцон гэрээний үндсэн дээр хамгаалж, аялал жуулчлалын үйл ажиллагаа эхлэн явуулж байсан болон шинээр эхэлсэн нөхөрлөл, хоршоодод дэмжлэг үзүүлж, жуулчид байрлуулах гэр, модон байртай болгох, ор дэвсгэр, хөнжил гудас, нарны зай, гэрэлтүүдэг, хөргөгч гэх мэт ахуйн хэрэглээний болон тогоо шанага, аяга таваг гэх мэт хоол, хүнсний ойр зуурын тоног хэрэгслээр хангасны дээр сургалтад хамруулж, аялал жуулчлал эрхлэх тал дээр арга зүйн зөвлөгөөг мэргэжлийн хүмүүсээр өгүүлж, туслаж дэмжиж ажилласан байна.

Төв аймгийн Баянцагаан сумын нутгийн захиргаатай хамтран Өлзийт нууранд ирдэг амрагч, сувилуулагчдын үйл ажиллагааг зохион байгуулалтад оруулах, нуурын усны бохирдлыг багасгах, шаврыг гадагш зөөж нөөцийг хомсдуулахыг зогсоох, гүний худаг гаргаж ундны цэвэр устай болгох замаар тохь тух, боловсон байдлыг хангах,

Хэнтий аймгийн Дархан сумын Дархан Хан уул, Баян-Өнжүүл сумын Зоргол Хайрхан, Дундговь аймгийн Гурвансайхан сумын Их газрын чулуу, Архангай аймгийн Хашаат сумын Номгон уул зэрэг газруудад цаашид нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хөгжих боломжийг нэмэгдүүлэх, нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор зэрлэг ан амьтан, түүний дотор аргаль хонь хамгаалах, тоо толгойг нь нэмэгдүүлэх, орчин тойрны иргэдийн болон нутгийн захиргааны байгууллагуудын идэвхийг сэргээх, аялал жуулчлал хөгжүүлэх санаачлага өрнүүлэхэд чиглэсэн ажлууд зохион байгуулсан байна.

**Үр дүнгийн тойм:** Манай оронд аялал жуулчлалын нөхцөл байдал төдийлөн сайн бус байгаа ч төсөлд хамрагдсан нөхөрлөл, төрийн бус байгууллагууд эхэлсэн ажлаа үргэлжлүүлэн аялал жуулчлалыг боломжийнхоо хэрээр хөгжүүлэхийн төлөө ажилласаар байна. 2003 онд МОН/03/11 төслөөр үйл ажиллагаагаа эхлүүлж жуулчны баазынхаа шавыг Төв аймгийн Баяндэлгэр сумын Гүн галуутайд тавьж байсан нутгийн иргэдийн “Гүн галуут” холбоо төрийн бус байгууллага уг газрыг орон нутгийн хамгаалалтад авахуулж



Малчдын хангайн хишиг ТББ-ын гэр бааз. Өвөрхангай, Бат-Өлзий

тэндхийн аргаль хонины тоо толгойг эрс нэмэгдүүлсний дээр аялал жуулчлалын компани болон өргөжиж жил бүр олон тооны жуулчин хүлээн авдаг болжээ. Архангай аймгийн Тариат сумын Тэрхийн цагаан нуур, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Хятрууны болон Хустын рашаан, Зүүнбаян-Улаан сумын Чинмэнд хоршоо, Арвайхээр сумын Цагаан бургас, Хэнтий аймгийн Дадал сумын Балжийн тохой зэрэг газруудад аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлж байгаа нөхөрлөл, малчны бүлгийн жижиг гэр баазуудын үйл ажиллагаа үргэлжлэн явагдаж амрагч, аялагч, жуулчдыг хүлээн авч үйлчилгээ үзүүлэх үүргээ гүйцэтгэн тодорхой орлоготой ажиллаж байна. Эдгээр жижиг гэр баазууд нь тухайн орчиндоо эзэн болох, харж хамгаалах, мод, бут, сөөг тарих, тохижуулах зэрэг орчны экологийг сэргээн хамгаалах үйл ажиллагааг байнга явуулж байгаагийн дээр ард иргэд, жуулчиддаа нийгмийн болоод эрүүл мэндийн үйлчилгээг давхар үзүүлж байгааг сайшаан тэмдэглэж байна.

## Тав. ХАМТЫН ОРОЛЦООТОЙ ОЙН МЕНЕЖМЕНТ

### Эх орны ногоон хүрмийг хамгаалах нь

Ой мод бол дэлхийн дулаарлыг сааруулагч гол хүчин зүйлийн нэг бөгөөд гол, мөрний усны нөөцийг зохицуулан хамгаалах, цэвэршүүлэх, хөрсний элэгдэл эвдрэлээс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, хүлэмжийн хийг шингээх, амьтан, ургамал, бичил биетний амьдрах тааламжтай орчныг бүрдүүлэх, мөнх цэвдэгийг тогтоон барих зэрэг экологийн маш олон талын ач холбогдолтойн дээр түүний амьд бүрэлдэхүүнд мод, бут, сөөг, сөөгөнцөрүүд, өвслөг ургамлууд, хөвд, мөөг, замаг, хаг шавьжууд, амьтад, шувууд, сээр нуруугүйтэн, ургамал болон бичил организмууд хамаардаг байна. Манай улс ой модны нөөцөөр хомсхон орны тоонд орох ба ойг бүрдүүлэгч модлог ургамлууд төв Азийн эрс тэс уур амьсгалтай нөхцөлд зохицон ургадаг тул байгалийн жамаар нөхөн үржих чадвар сул, түймэр, хөнөөлт шавьж болон хүний зохисгүй үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд хялбархан өртдөг байна.

Манай орны ой бүхий талбай нийт нутгийн ердөө 9,1 хувийг эзэлдэг. Гэтэл ойн нөөцөд маань хомсдох аюул нүүрлэснийг хүн бүгд мэднэ. Олон шалтгаан байгаа ч хууль бусаар буюу хулгайгаар ашиглах, ойн түймэрт өртөх, хортон шавьжинд идэгдэх, түүнчлэн цаг уурын өөрчлөлтөөс үүдэн хатаж нөхөн ургалт нь муудаж буурах зэрэг голлох шалтгаанууд бий. Улс орон зах зээлд шилжсэний дараахнаас модны хулгай газар авч ойн нөөцөд ихээхэн хохирол учруулах болсныг зогсоохоор төр, засгаас авч хэрэгжүүлсэн хамгийн оновчтой арга хэмжээний нэг нь ойг хэсэгчлэн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагуудад гэрээгээр эзэмшүүлж хамтын оролцоотой ойн менежментийг нэвтрүүлсэн явдал байлаа. Засгийн газрын 1998 оны 125 дугаар тогтоолоор Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журмыг анх батлан гаргаснаас хойш орон нутагт ойн нөхөрлөлүүд олноор байгуулагдаж эхэлсэн бөгөөд оновчтой зохион байгуулалт, нийгмийн харилцаа, эрх, үүргийн хэрэгжилт, хөрөнгө хүчтэй холбоотой олон асуудалтай тулгарч байсныг харгалзан ЖТХ-өөс

тэднийг юуны өмнө чадавхижуулах, менежментийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд нь тусламж дэмжлэг үзүүлсээр иржээ. Энд нэмж нэг зүйлийг тэмдэглэхэд хэдийгээр хэрэгжүүлсэн төслийн тоо 30 байгаа ч эдгээр болон бусад төслүүдэд ямар нэг хэмжээгээр хамрагдаж чадавхижсан, хамтын оролцоотой ойн менежментийн талаар тус Хөтөлбөрөөс явуулсан олон үйл ажиллагаанд оролцсон ойн нөхөрлөлүүдийн тоо 300 шахам байна.

**Хэрэгжүүлсэн төслийн тоо:** 30

**Хамарсан нутаг дэвсгэр:** Архангай, Булган, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын зарим сумд

**ЖТХ-ийн санхүүжилт:** 179,372 ам. доллар

**Төсөл хэрэгжүүлсэн нөхөрлөлийн тоо:** 26

**Төсөл хэрэгжүүлсэн төрийн бус байгууллагын тоо:** 4

**Төсөл хэрэгжүүлэгчдээс гаргасан хөрөнгө:**

-мөнгөн: 48,515 ам. доллар

-материаллаг: 149,898 ам. доллар

**Үр ашиг хүртэгсдийн тоо:** 8000

**Үндсэн зорилтууд:** Хамтын оролцоотой ойн менежментийг Монгол улсад анх удаа хэрэгжүүлэхээр байгуулагдсан ойн нөхөрлөлүүдийг сургах, чадавхижуулах, модны суулгац үржүүлж ойд нөхөн тарилт, ойжуулалт хийх, ойн түймэр, өвчин, хортон шавьж болон хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх, ойгоос үр, боргоцой түүж бэлтгэх, ойн зарим дагалт баялаг ашиглах, зөгий үржүүлэх, ан амьтан хамгаалах, хүнсний ногоо тарих, гар урлал, аялал жуулчлал хөгжүүлэх гээд ойн менежментийн төлөвлөгөөнд нь тусгагдсан ажил, арга хэмжээгээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндсэн зорилтууд бүхий төслүүд хэрэгжсэн байна.

**Үйл ажиллагааны тойм:** Ойн нөхөрлөлийн гишүүд ихэнхдээ сумын төвд эсвэл ойгоосоо зайтай газарт малаа маллаж, тариа ногооньхоо ажлаа эрхлэн амьдардаг тул ойгоо харж хамгаалах, ойн менежментийн төлөвлөгөөнд туссан ажлуудаа хийхэд хүндрэлтэй талууд ажиглагдаж байсан тул нөхөрлөл, түүний гишүүдийг эзэмшиж байгаа

ойд нь ойртуулж үйл ажиллагаагаа явуулах боломжийг бүрдүүлэх нь маш чухал ач холбогдолтой байлаа. Үүний тулд хамтын эзэмшлийн ой руу нэвтрэх хэсгийн замын хажууд, эсвэл ойролцоох газарт жижиг торон хашаа татаж дотор нь мод үржүүлгийн эсвэл жимсний жижигхэн талбай байгуулж нөхөрлөлийн аль нэг гишүүнийг суурьшуулах, ах дүү, найз нөхдөө хүлээн авч амруулах гэр, жижиг модон байр барьж ашиглах зэргээр байнгын хүнтэй, харуул хамгаалалттай болгож орсон, гарсан хүмүүсийг хянах боломжтой болжээ.

Ойн нөхөрлөлүүдэд эзэмшлийнхээ ойн чөлөөнд эсвэл захад нь мод үржүүлгийн талбай байгуулахад дэмжлэг үзүүлснээр ойжуулалт, ойн менежментийн төлөвлөгөөний дагуу хийх ёстой нөхөн тарилтанд хэрэглэх шинэс, нарс, бургас зэрэг модноос гадна улиас хайлааснаас эхлээд жимсний болоод гоёл чимэглэлийн зарим модны суулгац үржүүлэн зарж борлуулан орлогоо нэмэгдүүлэх шинэ боломж гаргаж өгчээ.

Төсөлд хамрагдсан зарим ойн нөхөрлөлүүдийн хийж байгаа нэг чухал ажил бол ойн дагалт баялаг болох зарим төрлийн зэрлэг жимс, эмийн болоод ашигт ургамлуудыг намар түүж хөлдөөх, хатаах, савлаж борлуулах ажлуудыг хийдэг бөгөөд хэд хэдэн нөхөрлөл хэрэгжүүлсэн төслийнхөө хүрээнд ургамал хатаах байртай болсон. Мөн ойгоос төрөл бүрийн ургамлын үр түүн хатааж хэрэгцээтэй хүмүүс, байгууллагуудад нь нийлүүлж байгаа бөгөөд энэ чиглэлд сургалтууд явуулжээ.

Ойн нөхөрлөлүүд байгалийн балт ургамлуудтай хамгийн ойр байдаг тул нөхөрлөлүүдийг зөгий маллахад сургаж зөгийжүүлэх ажлыг хийсэн нь ихээхэн ирээдүйтэй арга хэмжээ болсон байна.

Зарим сайн ажиллагаатай нөхөрлөлийн холбоод болон нөхөрлөлүүдийг ажлын байртай болгох, түймэр унтраах гар багажаар хангах, боргоцой сайруулж үр ялган авах машин зэргээр хангаж ажилд нь дэм үзүүлсэн байна. Хэнтий аймгийн Биндэр сумын Нөхөрлөлүүдийн холбоо, мөн сумын Яргуй нөхөрлөл, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Эвийн хүч, Уран байгаль, Тэрэгт, Баянгол сумын Тод Хараа, Хан Хэнтий аав, Хатан Онон ээжийгээ хамгаалах холбоо, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Нөхөрлөлүүдийн холбоо зэргийг үйл ажиллагаагаа явуулах офисын ажлын байртай болгосон байна.

**Үр дүнгийн тойм:** Хамтын оролцоотой ойн менежмент нь хууль бус мод бэлтгэлийг үндсэнд нь зогсооход ихээхэн хувь нэмэр оруулсан арга хэмжээ болсон бөгөөд ЖТХ-ийн хөтөлбөрөөс 300-аад ойн нөхөрлөлийг энэ чиглэлд чадавхижуулах зорилгоор хийсэн сургалтууд, танилцах, харилцан туршлага солилцох аялалууд үр дүнгээ өгч тэдний мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлж улмаар зохион байгуулалт, үйл ажиллагаанд нь нөлөөлж, идэвхи чармайлтыг нь нэмэгдүүлж ажлын бүтээмжийг дээшлүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж чадсан болохыг тэмдэглэж байна.

Ойн нөхөрлөлүүдийг эзэмшиж байгаа ойд нь ойртуулах зорилгоор хийсэн ажлууд нь модны хулгай хумигдахад ихээхэн нэмэр тустай байсан юм. Мөн эзгүй ойд гаднын хүмүүс ирж дураараа дургих нь эрс багассан байна. Зарим газруудад ой руу мал орох хэсгийг тороор хаших арга хэмжээ авснаар малчид тийш нь малаа бэлчээхээ больж зулзаган модны амьдралт эрс нэмэгдэж ойн байгалийн нөхөн сэргэлт явагдаж байна.

Нөхөрлөлүүдийг ойн сангийнхаа дэргэд жимс болон бусад гоёл чимэглэлийн модны талбай, цэцэрлэгтэй болоход нь тусалж зөвшөөрөгдсөн талбайд ганц нэг хүлэмж тавьж өргөст хэмх, улаан

лооль, зарим нэг эмийн болон ховор ургамал тарьж зах зээлд нийлүүлэн амьжиргаандаа нэмэрлэхийг дэмжиж, зарим нөхөрлөлийн гишүүдийг гар урлалын сургалтад хамруулж гэр бүлээрээ оёдол, сийлбэр, сүлжмэл гэх мэт зүйлүүдийг хийж орлогын эх үүсвэртэй болоход нь тусламж үзүүлснээр тэдний орлого нь тодорхой хувиар нэмэгдэж чаджээ.

60 гаруй ойн нөхөрлөлийг зөгий маллах сургалтад хамруулж нөхөрлөл бүрт зөгийн тодорхой тооны бүл нийлүүлсэн нь тэдний сонирхлыг төрүүлж идэвхийг сэргээн орлогын шинэ эх үүсвэр бүрдүүлсэн чухал арга хэмжээ болсон бөгөөд цаашид ойн нөхөрлөлүүдийн хувьд өргөжүүлэн хийвэл зохих ажлуудын нэг болж байгаа юм.

Ойгоос эмийн болон цайны ургамал, жимс түүж бэлтгэх зэргээр ойн дагалт баялгийг зохистой хэмжээнд тогтоосон дүрэм, журмын дагуу ашиглах тал дээр ахиц гарсаар байна.



Хэнтий аймгийн Биндэр сумын Яргуй нөхөрлөлийн ажлын байранд

## Зургаа. ЭКОСИСТЕМ БОЛОН ГАЗАР, ХӨРСНИЙ НӨХӨН СЭРГЭЭЛТ

**Амьдралын суурь орчныг дэмжих нь**

Хүн төрөлхтнөөс сүүлийн хэдхэн зуун жилийн дотор байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөллийн улмаас дэлхийн бөмбөрцгийн маш олон чухал экосистемүүд доройтож, газар хөрсний элэгдэл эвдрэл хаа сайгүй ажиглагдах болсон нь амьд байгаль, түүний хүрээнд хүн төрөлхтний өөрийн нь оршин тогтноход ноцтой аюул занал учруулж байгааг бид бүхэн мэдэх билээ. Экосистемийн хэвийн үйл ажиллагаа алдагдан эргэлт буцалтгүйгээр өөрчлөгдөж доройтон улмаар экологийн сүйрэлд хүргэх, хүн төрөлхтөн болон амьд байгальд үзүүлж байгаа эсосистемийн үйлчилгээ зогсвол юу болохыг төсөөлөшгүй юм. Амьдралын эдгээр суурь орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлд ДДБОС-гаас дэлхийн хэмжээнд олон тооны төслүүдийг санхүүжүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд тэдгээрийн дотор түүний ЖТХ-өөс байгаль хамгаалах нөхөрлөлүүд, төрийн бус байгууллагуудаар дамжуулан хөдөөгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн олон төслүүд өөрсдийн цар хүрээндээ тодорхой арга хэмжээ, ажил, үйлчилгээг гүйцэтгэн чухал хувь нэмрийг оруулж байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

**Хэрэгжүүлсэн төслийн тоо:** 98

**Хамарсан нутаг дэвсгэр:** Архангай, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Орхон, Өвөрхангай, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын зарим сумд

**ЖТХ-ийн санхүүжилт:** 553,667 ам. доллар

**Төсөл хэрэгжүүлсэн нөхөрлөлийн тоо:** 64

**Төсөл хэрэгжүүлсэн төрийн бус байгууллагын тоо:** 34

**Төсөл хэрэгжүүлэгчдээс гаргасан хөрөнгө:**

-мөнгөн: 98,727 ам. доллар

-материаллаг: 486,697 ам. доллар

**Бусад хандивлагчийн санхүүжилт:** 26,760 ам. доллар

**Үр ашиг хүртэгсдийн тоо:** 8000

**Ерөнхий зорилтууд:** Байгалийн хэвийн үйл ажиллагаа нь зарим талаар алдагдаж доройтолд аажмаар орж байгаа хээр талын болоод говийн зарим экосистемийг орон нутгийн иргэдийн оролцоотойгоор хамгаалах, нөхөн сэргээх үр дүнтэй арга замуудыг хайх, туршиж үзүүлэх, иргэд, олон нийтийг сургах, татан оролцуулах, үр дүнг тооцож үнэлэх, сурталчлах, цаашдын үйл ажиллагаандаа сонгож нэвтрүүлэхэд чиглэсэн зорилтууд тавигджээ.

**Үйл ажиллагааны тойм:** Хээр талын болоод говийн бүсэд ихэвчлэн усны ил задгай эх үүсвэрийг хамгаалах зорилгоор мод тарих, чацарганы болон бусад жимсний жижиг талбай байгуулах талаар нутгийн иргэд, түүний дотор малчдын бүлгүүдийн санал санаачлагыг дэмжих, говийн бүсэд булаг шанд, баян бүрд, хармаг жимс, чихэр өвс, дэрстэй газруудыг тойруулан хашиж хамгаалах, ногооны жижиг талбай тойруулан хамгаалалтын зурвасууд байгуулах, ойн нөхөрлөлийн болон малчдын бүлгийн эзэмшлийн талбайг ногооруулах, хүлэмж, мод, бут бусад ногоон байгууламжтай болгох, элсний нүүдэл болон цөлжилтөнд өртөж эхэлсэн зарим газруудыг хашиж малын хөлөөс хамгаалан хөрсний өнгөн давхаргыг тогтоон өвс ногоо, бусад ургамал ургах нөхцлийг бүрдүүлэхтэй зэрэгцүүлэн худаг гаргаж иргэд, нөхөрлөлийн эзэмшлийн чацаргана жимсний талбай байгуулах замаар элсний нүүдэл, цөлжилтийг тухайн орчинд нь зогсоох, говь, хээрийн бүсэд булаг, шандны усыг түшиглүүлэн жижиг усан толио байгуулж хамгаалалтын зурвасын мод, жимсний жижиг талбай, хүнсний ногоо услахад ашиглах зэрэг ерөнхий чиглэл, сэдвүүдийн хүрээнд олон нөхөрлөл, малчдын бүлгүүдтэй хамтран ажиллажээ.

**Үр дүнгийн тойм:** Уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилт, цөлжилтийн нөлөөгөөр ус ундарга нь багассан гадаргын ил задгай усны эх үүсвэрийг хамгаалах үүднээс нийтдээ 24 булаг, шандыг хашиж хамгаалснаар ундарга нь хүн малын хөл, элдэв техник хэрэгслийн нөлөөнд орохоос сэргийлж орчныхоо амьдралыг тэтгэх үйлчлэлээ хадгалж чаджээ. Говийн бүсийн зарим сумдад баян бүрдүүд, хармаг жимс, чихэр өвс, дэрс бүхий талбайнуудын хашиж хамгаалах ажлыг орон нутгийн малчид, хөдөлмөрчидтэй хамтран хийснээр тэдгээрийг устаж үгүй болох аюулаас урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ тэднээс орчны экосистем болон малчид, иргэдийн ахуй амьдралд үзүүлэх

эерэг нөлөөг хэвээр үргэлжлэх нөхцлийг хангаж өгчээ. Доройтолд орсон тухайн орчны газар, хөрс, экосистемийг сэргээх зорилгод хуурайшилт, ганд арай илүү тэсвэртэй модны төрлүүд, тэдгээрийн дотор чацаргана жимсний модыг иргэд, нөхөрлөлийн гишүүдийн амьдрах орчны ойролцоо, ирээдүйд тэдний эзэмшлийн цэцэрлэг болохоор олон газар тариулсан нь байгальдаа эерэгээр нөлөөлөхийн сацуу өрхийн орлогын болоод амин дэмийн хэрэгцээг хангах нэг шинэ эх үүсвэр болсон байна. Цөлжилт, элсний нүүдэлд өртсөн болон элэгдэл эвдрэлд орж байгаа газруудыг нутгийн иргэд, малчид, байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн эзэмшилд орон нутгийн захиргаанаас бодлого, зохион байгуулалттайгаар олгуулах боломжийг эрэлхийлж хэлэлцэн шийдвэрлэсний дараа иргэдэд тусламж дэмжлэг үзүүлж тухайн орчны нөхцөл байдлыг сайжруулж ногооруулан юуны өмнө газар, мод, бутнаас эхлээд өөрийн гэсэн өмч хөрөнгөтэй болгох туршилтын төслүүд маш амжилттай хэрэгжсэнийг тэмдэглэж байна.



Газрын эвдрэл, хөрсний элэгдэлтэй тэмцэхээр чацарганы талбай байгуулж байгаа нь

## Долоо. ОРОН НУТАГТ ХЭРЭГЛЭГДЭХ АРГА ТЕХНИКУУД

### Эрчим хүч, цаг хугацаа хэмнэх, хөдөлмөр хөнгөвчлөх, бүтээмж нэмэгдүүлэх боломжуудыг ашиглах нь

Шинжлэх ухаан, техник, технологийн үсрэнгүй хөгжлийн эринд амьдарч байгаа бидний хувьд орчин үеийн дэвшилтэт техник, технологи болон шинжлэх ухааны ололт амжилтыг аль болохоор цаг алдалгүй ашиглаж амьдрал ахуйдаа нэвтрүүлэх нь чухал ач холбогдолтой билээ. Хөдөөгийн иргэд маань эрчим хүч, цаг хугацаа хэмнэсэн, хөдөлмөр хөнгөвчилсөн энгийн тоног хэрэгслүүдээс эхлэн орчин үеийн өндөр бүтээмжтэй машин, техник, тоног төхөөрөмжүүдийг үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэгцээндээ ашиглаж хөдөлмөрийн бүтээмжээ сайжруулахгүйгээр амжилтанд хүрэхэд асар хүнд болжээ. Зөвхөн мод тарих ажлаар жишээ авахад хэдэн жилийн өмнө модны нүхийг хүрээ ашиглан гараар ухдаг байсан бол өнөөдөр трактороор эсвэл мотороор ажилладаг гар өрмөөр ухдаг болсон нь хөдөлмөрийн бүтээмжийг олон арав дахин хөнгөвчилж байгаа юм. Манай хөдөө орон нутагт гарын дүйтэй, техник сэтгэлгээ сайтай олон хүмүүс байдаг нь аливаа энгийн жижиг тоног төхөөрөмжүүдийг өөрсдөө хийгээд ашиглах сайхан боломжийг олгож байдаг. Тэд малын бууцаар шахмал түлш үйлдвэрлэх гар болон цахилгаан тоног төхөөрөмжүүд, голын урсгал ашиглан ус татах, нарны энергийг дулааны болон цахилгаан эрчим хүчинд хувиргах гэх мэт олон төхөөрөмжүүдийг өөрсдийн боломжоор хийж ашиглаж байгаагийн дээр тухайн орчныхоо нөхцөлд тохируулан хямд төсөр аргаар олон төрлийн хүлэмжүүд угсарч нарийн ногоо тарих, суулгац үржүүлэхдээ ашиглаж байгаа нь үр өгөөжтэй байна.

**Хэрэгжүүлсэн төслийн тоо:** 16

**Хамарсан нутаг дэвсгэр:** Архангай, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Орхон, Өвөрхангай, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын зарим сумд

**ЖТХ-ийн санхүүжилт:** 154,364 ам. доллар

**Төсөл хэрэгжүүлсэн нөхөрлөлийн тоо:** 8

**Төсөл хэрэгжүүлсэн төрийн бус байгууллагын тоо:** 8

**Төсөл хэрэгжүүлэгчдээс гаргасан хөрөнгө:**

-**мөнгөн:** 74,541 ам. доллар

-**материаллаг:** 103,486 ам. доллар

**Үр ашиг хүртэгсдийн тоо:** 1500

**Үндсэн зорилтууд:** Хөдөөгийн иргэд ахуй, амьдралын хэрэгцээндээ эрчим хүч, цаг хугацаа хэмнэж хөдөлмөр хөнгөвчлөн бүтээмж нэмэгдүүлдэг энгийн тоног хэрэгслүүдийг ашиглаж дадах, зарим төрлийн тоног хэрэгсэл, төхөөрөмжийг өөрсдөө хийж ашиглахыг дэмжихэд эдгээр төслүүдийн үндсэн зорилт оршиж байна.

**Үйл ажиллагааны тойм:** Энэ чиглэлд явуулсан үйл ажиллагааг хоёр үндсэн хэсэгт хувааж болно. Нэг нь зах зээлээс бэлэн төхөөрөмж авч нийлүүлэн хэрэглүүлж сургах бол нөгөө нь зарим төрлийн ахуйн болон үйлдвэрлэлийн тоног хэрэгсэл, төхөөрөмжийг иргэд өөрсдөө сэдэж хийгээд ашигласан үйл ажиллагаанууд байв. ЖТХ-өөс нарны хавтангуудыг гэрэлтүүлэх төхөөрөмж болон ус татах шахуургуудын хамт 70 гаруй нөхөрлөлд нийлүүлж хэрхэн ашиглах зааврыг өгсний дээр био газ гаргах, ноос угаах, ус халаах, зөгийн зохиомол хээлтүүлэг хийх болон бал савлах багаж, төхөөрөмжүүдийг зарим нөхөрлөлд туршилт, үйлдвэрлэлийн зориулалтаар нийлүүлсэн байна.

Малын бууцаар шахмал түлш үйлдвэрлэх гар багаж болон цахилгаан төхөөрөмжийг Өвөрхангай, Дундговь аймагт орон нутагт нь хийлгэж малчид, иргэдэд тарааж айл өрхүүд өөрсдөө түлшээ бэлтгэхэд ашиглаж байна. Урсгал усны хүчийг ашиглан ус татах төхөөрөмж бүтээж хэдэн хэдэн газар туршсан нь цаашид улам сайжруулан ашиглах боломжтойг харуулав. Мөн нарны энергийг дулааны болон цахилгаан эрчим хүчинд хувиргах төхөөрөмжүүдийг иргэд өөрсдийн боломжоор хийж радио ажиллуулах, гар утас цэнэглэх, ус буцалгаж хоол унд хийх гэх мэт ахуйн хэрэгцээнд ашиглаж байна. Хоёр төслөөр иргэдийн нөхөрлөлд хүлэмжний эд ангиуд нийлүүлснээр тэд тухайн орчныхоо нөхцөлд тохируулан хямд төсөр аргаар олон төрөл, хэлбэрийн хүлэмжүүдийг санаачлан хийж модны суулгац үржүүлэх, нарийн ногооны үрсэлгээ хийхэд ашиглаж байна. Дархан хотод хуванцар хаягдлыг хайлуулан хэвэнд цутгаж хашаа, хайс, сандал, траншейны таг гэх мэт 20 гаруй төрлийн бүтээгдэхүүн

үйлдвэрлэж байгаа “Гялгар уут” нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжсэн нь нийгэмд ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ болсон байна. Элс шороо уутлан тусгай технологиор малын хороо, гахай, шувууны байр, сэрүүний улиралд ашиглах хүлэмж, зoorь, жижиг офисын барилга, бараа хадгалах агуулах зэргийг барьж ашиглалтад оруулсан нь дулаанаа сайн хадгалдаг, мод болон барилгын бусад материал хэмнэсэн, хэрэглэгчдийнхээ хэрэгцээг хангасан байгууламжууд болсон байна. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн эрдэмтэн багш нартэй хамтран нарын энергиэр ажилладаг 20 ширхэг хөргөгч угсран хөдөөгийн малчид хөдөлмөрчдийн хэрэгцээнд нийлүүлсэн нь үр дүнтэй ажил болжээ. Мөн тракторт угсран модны нүх ухдаг өрмүүдийг нөхөрлөлүүдээр хаягдаж төмөр ашиглуулан хийлгэсэн нь тухайн орон нутагтаа мод тарих, хашааны нүх ухах зэрэг ажлуудыг ихээхэн хөнгөлчилж байна.

**Үр дүнгийн тойм:** Малын бууцаар шахмал түлш үйлдвэрлэх 600 гаруй гар багаж, 5 цахилгаан төхөөрөмжийг Өвөрхангай, Дундговь аймгийн 10 гаруй сумдын малчид хөдөлмөрчдөд тарааж жилд дунджаар 2000 тонн шахмал түлш бэлтгэх боломж, хүчин чадлыг бий болгожээ. Хөдөөгийн иргэд нарны энергийг зөвхөн гэрэлтүүлэг болон хөргөлтөд ашиглаад зогсохгүй жижиг радио хүлээн авагч ажиллуулах, гар утас цэнэглэх, ус халаах, хоол унд бэлтгэхэд хүртэл ашиглахад боломжтойг ойлгож мэдэрч суралцсаар байна. Зах зээлийн үнээр дулааны улирлын хүлэмж худалдан авч чадахгүй иргэд өөрсдийн нөхцөл байдалд тохируулан бага оврын хямд төсөр хүлэмжүүд барьж ашиглах болсны зэрэгцээ блок, ууталсан шороо болон бусад барилгын материалаар цаг агаар сэрүүн байхад буюу 3 дугаар сараас эхлэн 10 сарыг дуустал хугацаанд ашиглаж болох хүлэмжүүд барьж хүнсний ногоо ургуулах, модны суулгац үржүүлэх гэх мэт ажлын хугацааг бараг 2 дахин уртасгаж байгаа болно. Өөрөөр хэлбэл, нэг хүлэмжнээс жилд 2 удаа ургац авах боломжийг бүрдүүлж байна гэсэн үг юм.

Япон улсын Хирошимогийн их сургуулийн технологиор элс шороог уутлан төрөл бүрийн байгууламжууд барьж туршсаны дотор Сэлэнгэ аймгийн Баянгол суманд үхрийн фермийн байр, Түнхэл тосгонд офисын байр, Мандал, Баянгол сумдад аялал жуулчлалын зориулалтаар зочин хүлээн авах байр, Төв аймгийн Баянцогт сумын нутагт офисын байр, өвлийн хүлэмж, шувууны өвлийн байр зэрэг

өвлийн цагт дулааны алдагдалгүй, эрчим хүч хэмнэсэн байгууламжууд үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

Дархан хотод Гялгар уут нэртэй нөхөрлөл анх хуванцар хог хаягдлыг цуглуулан хайлуулж зарим төрлийн бүтээгдэхүүн хийж эхэлж байсан бол хэдхэн жилийн дараа Сан Оригу нэртэй компани болон өргөжиж Дубайн олон улсын нэр хүндтэй шагнал хүртэн өөрийн салбаруудаа Улаанбаатар хотод нээж бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг олшруулахын зэрэгцээ технологийн шинэ шийдлийн төлөө амжилттай ажиллаж байна.

Хөргөх Технологи Судалгааны Төвийн санаачлагыг дэмжин түүний лабораторийг түшиглэн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр ажиллах бага оврын 20 ширхэг хөргүүрийг туршилтын журмаар угсарч хөдөөгийн хэрэглэгчдийн хэрэгцээнд нийлүүлсэн бөгөөд энэхүү төслийн хэрэгжилтийн явцад хийсэн судалгаа, шинжилгээний баримт бичиг, туршлагадаа тулгуурлан “Сэргээгдэх эрчим хүчээр ажиллах бага оврын хөргүүр” нэртэй номыг магистр, докторант оюутнуудын судалгааны ажилд зориулан хэвлүүлж цаашдаа бага оврын хөргүүрийн тоног төхөөрөмжийн худалдаа, засвар үйлчилгээний иж бүрэн үйлдвэр байгуулах асуудлыг судалж байгаа юм байна.



“Нарны ач” нөхөрлөлийн хийсэн нарны тогоо

## Найм. ЗАГАС ХАМГААЛАЛ

### Загас хамгаалахад иргэд, нөхөрлөлийн оролцоог нэмэгдүүлэх нь

Манай орон цэнгэг усны загасны нөөцөөр тийм ч хомсхон байгаагүй үе саяхан. Гэтэл уур амьсгалын өөрчлөлт, амьдрах орчны доройтол, хэт агналт зэрэг хэд хэдэн шалтгааны улмаас манай орны загасны нөөц сүүлийн 30-аад жилийн дотор эрс багасаад байгаа билээ. Ялангуяа зах зээлд шилжсэн үеэс эхлэн хулгайн анчид тэсрэх бодис болон залмагийн тор ашиглан агналт хийх болсон нь загасны нөөцийг ихээхэн хэмжээгээр хорогдуулжээ. Түүнчлэн загас агнуурын багаж хэрэгсэл сайжирч, туулах чадвар сайтай унаа элбэг болсон нь олон төрлийн үнэт загасыг хаа байгаа газарт нь хүрч агнахад улам хялбар болгосон байна. Загасны нөөц хомсдоход хүргэсэн өөр нэг хүчин зүйл нь аж ахуйн үйл ажиллагаа юм. Загасны идээшил нутагт алт олборлолт ихээр явуулж ой модыг огтолж орчныг талхалсны дээр органик бохирдол нэмэгдсэн нь ийн нөлөөлсөн байна. Туул, Ерөө, Орхон голуудын сав газруудад алт олборлолтыг их хэмжээгээр хийснээс гол, горхины хурдсанд тунадас ихээр үүсч загасны үржил, хөврөлийн хөгжлийн эхний болон дараа дараагийн үе шатуудад аюул учруулах болсон байна. Мөн цианид, мөнгөн ус ашиглан алт ялгах зэрэг хортой, хориотой үйл ажиллагаануудыг нууцаар хийдэг нь загас болон усны бусад организмуудыг хордуулж улмаар мөхөлд хүргэх аюултай байдаг байна. Иймээс загас хамгаалахад байгаль хамгаалах нөхөрлөлүүд болон нутгийн ард иргэдийг татан оролцуулах, загас хамгаалах чиглэлд тэдний хийж чадах боломжит үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нь чухал байсан тул ДДБОС-гийн ЖТХ-өөс 9 жижиг төсөл хэрэгжүүлжээ. Өргөн удам нутагтай, хүн амын нягтшил багатай манай улсын хөдөө орон нутагт загас болон бусад зэрлэг ан амьтдыг хамгаалахад байгаль хамгаалах нөхөрлөл, нутгийн иргэдийн оролцоо онцгой буюу магадгүй шийдвэрлэх ач холбогдолтой ч байж магадгүй юм. Загасыг хамгаалах, түүний нөөцийг арвижуулахад хөдөөгийн иргэд, малчид, тариаланчид

маань чухам юу хийж чадах талаар зөвлөлдөх, загасны үржил, өсөлт, хөгжилт, нүүдэл, шилжилт хөдөлгөөн зэрэг олон зүйлийн талаар тэдэнд анхан шатны мэдлэг олгохоос эхлээд загасны үржих нөхцлийг хангасан жижиг цөөрөм байгуулж турших хүртэл олон ажлуудыг хийж байж иргэдийн ухамсарт нөлөөлөх, тодорхой ахиц дэвшлийг бий болгохоор зорьж ажилласан байна.

**Хэрэгжүүлсэн төслийн тоо:** 9

**Хамарсан нутаг дэвсгэр:** Булган, Сэлэнгэ, Төв аймгуудын зарим сумд

**ЖТХ-ийн санхүүжилт:** 95,110 ам. доллар

**Төсөл хэрэгжүүлсэн нөхөрлөлийн тоо:** 5

**Төсөл хэрэгжүүлсэн төрийн бус байгууллагын тоо:** 4

**Төсөл хэрэгжүүлэгчдээс гаргасан хөрөнгө:**

-мөнгөн: 29,512 ам. доллар

-материаллаг: 37,689 ам. доллар

**Үр ашиг хүртэгсдийн тоо:** 2000 орчимд хүнд мэдээлэл хүрсэн

**Үндсэн зорилтууд:** Хэрэгжүүлсэн төслүүд нь байгаль хамгаалах нөхөрлөлүүд болон орон нутгийн ард иргэдийг загас хамгаалах арга хэмжээнд татан оролцуулах, энэ чиглэлээр тэдний сонирхож байгаа болон хийж чадах ажлуудыг дэмжих, сургалт, семинарт хамруулах, мэдлэг, мэдээллийг нь нэмэгдүүлэх, голын дагууд загасны үржлийн цөөрмийг хамгаалах, шинээр жижиг усан сан, цөөрөм байгуулж загасны үржилтэд тус нэмэр болох, загас, амьтдыг хайрлан хамгаалах сэтгэхүй, ухамсарыг иргэдэд төлөвшүүлэх үндсэн зорилтуудыг агуулжээ.

**Үйл ажиллагааны тойм:** Загас хамгаалах хүсэл, тэмүүлэлтэй иргэд, нөхөрлөлийн гишүүд болон загасны жижиг аж ахуй сонирхогчдыг хээрийн сургалт, семинарт хамруулах, зохих мэдээлэл, гарын авлагаар хангах, жарамгайн тархац, амьдралын орчин, эрсдэлийн нөхцөлүүдийг загасны мэргэжилтнүүдтэй хамтран судлах, жарамгайг бусад загасны идэш тэжээл болохоос хамгаалах зориулалтын тор, торон төхөөрөмж хийж тавьж турших, том гол руу цутгадаг булгийн усыг жижиг шороон далангаар хааж цөөрөм үүсгэн байгалийн жамаар загас

үржүүлж эх голд нийлүүлэх, голын зарим салаа, булан тохойнуудыг хамгаалж загас үржихэд дэмжлэг үзүүлэх, нуурын усны гаралтыг жижиг цементэн далангаар хааж түвшинг нэмэгдүүлэх, нуур руу зэргэлдээх голоос суваг татаж усыг нэмэгдүүлэх, Сэлэнгэ, Орхон, Хараа голуудын дагуу тухайн орчны байгалийн тогтоцыг ашиглан жижиг усан сангууд байгуулж зарим төрлийн загас үржих нөхцлийг бий болгох, Туул голын татамд Төв аймгийн Эрдэнэ сумын Тулгат гацааны ойролцоо урсгалгүй болсон салааны голдрилыг ашиглан жижиг хиймэл усан сан байгуулж загасыг байгалийн аясаар үржих нөхцөлийг бүрдүүлэх, цаашдаа зохиомлоор үржүүлэх зорилгоор түрс өсгөх цех барих зэрэг үйл ажиллагаануудыг явуулжээ.

**Үр дүнгийн тойм:** Юуны өмнө төсөл хэрэгжсэн газруудын ойр орчны ард иргэд болон төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авсан иргэд загасыг хамгаалахын мөн чанарыг сайтар ойлгож ухамсар, сэтгэхүйд нь тодорхой өөрчлөлт гарсан гэж үзэж байгаа. Мөн энэхүү ном гарсны дараа түүнийг олж үзэх, унших хүмүүст ч цаашид нөлөө үзүүлнэ гэдэгт эргэлзэхгүй байна. Дээр дурдсан үйл ажиллагаа тус бүр нийгэм, ард иргэдэд ямар нэг хэмжээгээр нөлөөлсний дээр тухайн орчиндоо загас хамгаалахад бодитой хувь нэмрээ оруулсаар байгаа төдийгүй цаашид ч энэ чиглэлээр олон сайхан ажлын эхлэл, сэжүүр болно гэдэг итгэлийг төрүүлж байна. Эдгээр хийсэн ажлуудаас 2 ажлыг цаашдын ач холбогдлынх нь хувьд онцлон дурьдмаар байна. Булган аймгийн Сэлэнгэ сумын нутагт Сэлэнгэ мөрний хөвөөн дээр булгийн усаар тэжээгддэг хиймэл цөөрөмд загас үржүүлэх ажлыг “Жарамгайн цөөрөм” нөхөрлөлийн ахлагч, иргэн Л.Баатар 2009 оноос хойш хийсээр иржээ. Уг цөөрмийг Сэлэнгэ мөрний салаатай төмөр хоолойгоор холбож анхлан хавар голын мөс гэсэх үед онгойлгож загас оруулсан бөгөөд хавар, зуны туршид тэнд зарим төрлийн загасны үржил явагдаж намар болоход хоолойны аман дээр тусгай тор тавьж цөөрмийн усыг гол руу юүлэхэд түүнтэй хамт тэр жилийн төл загаснууд бөөнөөр гарч голд нийлдэг байна. Ингэснээр жил бүр байгальд маш олон тооны төл загас нийлүүлж байгаа юм. Нөгөө нэг ажил нь Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, загас судлаач, “Жижиг горхи” төрийн бус байгууллагын тэргүүн Г.Баасанжав Туул голын урсгалгүй болсон салааны голдрилыг түшиглэн усан сан байгуулж

загасыг байгалийн болон зохиомол аргаар үржүүлэх орчныг бий болгох төслийг хэрэгжүүлж ирээдүйн томоохон ажлын эхлэлийг тавиад байна. Түрс өсгөөрийн аппаратуудаар тоногдсон цех, ус хуримтлуулах цөөрөм, хамгаалалтын хашаа зэргийг барьж цахилгааны найдвартай эх үүсвэрт холбон Туул-Тэрэлж голын уулзвар орчимд загасны тархац, байршил, улирлын нүүдэл хөдөлгөөн, усны бусад амьтан, ургамлын өнөөгийн байдалд ажиглалт, судалгаа хийжээ. Энэ ажил цаашид үргэлжилснээр Монгол оронд загас хамгаалах, цөөрмийн байгууламжийг зөв чанартай хийж загас, усны амьтдын амьдрах орчин нөхцлийг сайжруулж голын ай савын биоценозын нэгэн хэсэг болох загасны популяцийг нөхөн сэргээж өсгөн үржүүлэхэд ихээхэн тус дэм болох туршилт судалгааны төв бий болох юм.



Ишгэн нуурын орчимд хийсэн хээрийн сургалт, Дархан-Уул, Хушаат

## Ес. ЭМИЙН БОЛОН ХОВОР УРГАМЛЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ, ТАРИМАЛЖУУЛАХ

### Эх орны үнэт баялаг-эмийн ургамлыг хамгаалах нь

Хүний зохисгүй үйл ажиллагааны уршгаар дэлхийн уур амьсгал өөрчлөлтөд орж, хөрс, ус, байгалийн ургамалжилт зэрэг хүн төрөлхтний өөрийнх нь оршин тогтнох орчныг бүрдүүлэгч хэсгүүд эрс доройтож эрүүл амьдрах боломж нөхцөл улам муудсаар байгаа билээ. Байгалийн ургамалдаа нэн хүндэтгэлтэй хандаж, сүслэн биширч, түүнийг зөвхөн амин чухал хэрэгцээ тохиолдоход байгаль эхдээ мөргөн гуйж хүртдэг байсан өвөг дээдсээс уламжлагдан ирсэн ёс заншил алдагдаж, ялангуяа эмийн болон ховор ургамлыг ашиг хонжоо олох зорилгоор хаа дуртай газраасаа хайр найргүй түүж устгах, гадаадад их хэмжээгээр гаргах зэрэг олон зүй зохисгүй үйлдлүүд гарах болсон нь нэн харамсалтай. Эх орны үнэт баялаг болсон эмийн болон ховор ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, аль болох тарималжуулан ашиглах нь зөвхөн өнөө үеийн төдийгүй дараа дараагийн үеийнхний байнга анхаарч тасралтгүй хийж байх ёстой ажил мөн тул тус Хөтөлбөрөөс юуны өмнө эмийн болон ховор ургамлын нөөцийг хамгаалахын ач холбогдлыг ард иргэдэд ойлгуулах, тэднээр өөрсдөөр нь хамгаалуулах, зарим төрлийн ургамлыг тариулж турших, ашиг тусыг мэдрүүлэх, байгалиас бэлдэж байгаа эмийн ургамлын тоо хэмжээг багасгаж оронд нь тарималжуулсан ургамал ашиглахад хувь нэмрээ оруулах эхлэлийг тавих зорилгоор хэд хэдэн жижиг төсөл хэрэгжүүлсэн байна. Хэдийгээр эмийн болон ховор ургамлыг тарьж ургуулах, тарималжуулах нь хэн хүссэн бүхний хийж чадаад байх ажил биш ч төсөл хэрэгжүүлсэн нөхөрлөлүүд, төрийн бус байгууллагууд хүчин чармайлтынхаа үр дүнд тодорхой амжилтанд хүрч чадсан байна.

**Хэрэгжүүлсэн төслийн тоо:** 13

**Хамарсан нутаг дэвсгэр:** Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Төв, Хэнтий аймгуудын зарим сумд

**ЖТХ-ийн санхүүжилт:** 91,600 ам. доллар

**Төсөл хэрэгжүүлсэн нөхөрлөлийн тоо:** 5

**Төсөл хэрэгжүүлсэн төрийн бус байгууллагын тоо:** 8

**Төсөл хэрэгжүүлэгчдээс гаргасан хөрөнгө:**

-**мөнгөн:** 22,609 ам. доллар

-**материаллаг:** 58,963 ам. доллар

**Үр ашиг хүртэгсдийн тоо:** 400

**Үндсэн зорилтууд:** Эмийн ургамлыг зөв зохистой түүж ашиглах, хатаах, савлахад энэ чиглэлээр ажилладаг иргэд, нөхөрлөлүүдийг сургах, эмийн болон ховор ургамлыг ургаж буй байгаль орчинд нь хамгаалах, үрийг нь түүж тарьж турших, эмийн зарим зэрлэг ургамлыг эрдэмтэд, мэргэжилтнүүдийн оролцоотой тарималжуулах, ховор болон ашигтай ургамлын цэцэрлэг байгуулах зэрэг зорилтуудыг тавьж хэрэгжүүлсэн байна.

**Үйл ажиллагааны тойм:** ЖТХ-ийн төслөөр хийсэн дорвитой ажлуудын нэг нь Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоноос баруун урагш 6 км-т байрлаж буй Ховор ургамал судлах, тарималжуулах төвтэй хамтран 30 гаруй төрлийн нэн ховор, ховор болон ашигт ургамлыг тарималжуулах ажлыг дэмжих төслийг биологийн ухааны доктор, профессор Х.Жамьяандорж, Х.Отгонбилэг нарын удирдлагаар 2007 онд амжилттай хэрэгжүүлж ховор ургамлын цэцэрлэгийн хөгжилд багагүй хувь нэмэр оруулсан үйл ажиллагаа юм. Төв аймгийн Алтанбулаг, Баянхонгор аймгийн Богд, Өмнөговь аймгийн Далан задгад суманд эмийн ургамлууд түүний дотор чихэр өвс, арцыг нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах, байгальдаа нөхөн сэргэхэд дэмжлэг үзүүлсэн бол Өвөрхангай аймгийн Хархорин, Булган аймгийн Рашаант, Төв аймгийн Борнуур, Архангай аймгийн Ихтамир, Хэнтий аймгийн Дадал зэрэг сумдад алтангагнуур, хумсанцэцэг, толбот силибум, ягаан цээнэ, чихэр өвс, жигд, дэрэвгэр жиргэрүү, лидэрийг үрээр тарьж туршин амжилттай ургуулсан байна. Орхон аймгийн Баян-Өндөр сумын “Мүгээ” нөхөрлөлийн ахлагч Я.Тоолой байгалийн алтангагнуурын үрийг түүж өөрийн гаргасан био ялзмагт хөрс бүхий хүлэмжинд тарьсан нь маш амжилттай болсны дээр нэг зуны туршид 6 см-ээс урт ургасан үндсийг талбайд суулган үржүүлж байна.

**Үр дүнгийн тойм:** Уламжлалт анагаах ухаанд эрт дээр үеэс хэрэглэж ирсэн зарим эмийн ургамлын нөөцийг тухайн байгаль орчинд

нь хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр орон нутгийн олон иргэд, малчид байгалийн үнэт баялаг болсон эмийн болон ховор ургамлын үнэ цэнийг илүү ихээр мэдрэх болсон байна. Нутгийн зарим иргэдийн яриагаар тэд гаднын элдэв ургамал сурагласан хүмүүст газар зааж өгөх нь байтугай өөр хоорондоо ховор ургамлын талаар нарийн мэдээлэл солилцохоо больсон байна. Үүнийг зөв хандлага гэж үзэхээс өөр аргагүй. Толбот силибум, хумсан цэцэг, лидэр, жигд зэрэг хэд хэдэн ургамлыг бага хэмжээгээр тарьж зах зээлд нийлүүлдэг иргэд, нөхөрлөлүүд бий болоод байгаа бөгөөд энэ нь нутгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, шинээр ажлын байр бий болгоход чухал ач холбогдолтой, маш ирээдүйтэй ажил юм. Учир нь Монгол орны шимт хөрсөнд тарималжуулан ургуулсан эмийн ургамал дэлхийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй үнэ цэнэтэй бүтээгдэхүүн болох цаг удахгүй ирнэ. Цаашид энэ чиглэлд орон нутгийн төр захиргааны байгууллагууд бодлогоо тодорхойлж дэмжиж ажиллууштай байна. Харин ЖТХ нь цаашдаа өөрийн хуримтлуулсан туршлага дээрээ үндэслэн зарим төрлийн эмийн болоод ховор ургамлын үр нийлүүлэх, тарих арга, технологийг мэргэжлийн хүмүүсийг оролцуулан олон иргэд, нөхөрлөлийг нэг дор хамруулан зааж сургах тал дээр түлхүү ажиллаж аль болох богино хугацаанд илүү үр дүнд хүргэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.



Хэнтий аймгийн Дэлгэрхаан суманд тарьсан эмийн ургамлын цэцэрлэгийн хэсэг

Арав. ШАХМАЛ ТҮЛШ

### “Нөхөн сэргээгддэг” нөөцийг ашиглах нь

2016 оны мал тооллогын дүнгээр манай улсын малын тоо 61.5 саяд хүрсний 4.1 сая нь үхэр байсан байна. Үхрийн баас нь гэр ахуйн нөхцөлд шахмал түлш хийхэд хамгийн тохиромжтой бөгөөд жил бүр хэдэн сая тонноор гарч байгальд хаягдаж байдаг өөрөөр хэлбэл нөхөн сэргээгддэг нөөц юм. Харин түүнийг хатаж аргал болсны дараа багахан хэсгийг нь малчид түлшинд хэрэглэсээр ирсэн уламжлалтай. Малын баас, бууц нь ерөнхийдөө нар, салхины нөлөөгөөр задран байгальд шингэхийн зэрэгцээ бороо, цасны усаар угаагдан зөөгдөж нуур, гол, мөрний усанд орж тэдгээрийг бохирдуулдаг эх үүсвэрүүдийн нэг болдгийг бид мэдэх билээ. Аргал, хөрзөнг ихэвчлэн говь, хээрийн бүсэд малчид голцуу түлшинд хэрэглэж байгаа бол хангайн бүсэд эдгээр нь хог болон хаягдсаар байна. Аргал, хөрзөн нь ой модны нөөцөөр хомсхон манай орны хувьд цаашид олон жил малчид, иргэдийн ахуйд түлшний чухал эх үүсвэр байсаар байх тул малын баас, бууцыг орон нутагт гар багажаар болон жижиг үйлдвэрлэлийн аргаар шахаж түлшинд ашиглах нь байгаль орчин, ялангуяа мод, бутыг хамгаалахад чухал ач холбогдолтой юм. Нөгөө талаар үнэ ихтэй нүүрсийг хол газраас татаж авахад гарах тээврийн болон бусад зардлыг хэмнэх боломжийг иргэдэд олгож байгаагаас гадна говь, хээрийн бүсэд бут, сөөгийг сүйтгэж цөлжилт болон газрын элэгдэл эвдрэлийг нэмэгдүүлэхгүй байх сайн талтай. Мөн малын баас, бууцыг нүүрсний нунтаг хаягдал болон модны үртэстэй хольж шахмал түлш хийснээр байгаль орчны бохирдлыг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулж байна. Одоогоор сум, суурин газрууд, томоохон хотуудын эргэн тойронд үнээний фермүүд байгуулагдаж байгаа байдал, алсдаа малчид хагас суурин, суурин амьдралд аажмаар шилжих хандлага ажиглагдаж байгаа нь малын баасыг боловсруулах, ашиглах шаардлагыг нэмэгдүүлж байна.

**Хэрэгжүүлсэн төслийн тоо:** 12

**Хамарсан нутаг дэвсгэр:** Архангай, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Орхон, Өвөрхангай, Говь-Алтай, Төв, Сэлэнгэ, Хэнтий, аймгуудын зарим сумд

**ЖТХ-ийн санхүүжилт:** 77,280 ам. доллар

**Төсөл хэрэгжүүлсэн нөхөрлөлийн тоо:** 5

**Төсөл хэрэгжүүлсэн төрийн бус байгууллагын тоо:** 7

**Төсөл хэрэгжүүлэгчдээс гаргасан хөрөнгө:**

**-мөнгөн:** 23,673 ам. доллар

**-материаллаг:** 59,751 ам. доллар

**Үр ашиг хүртэгсдийн тоо:** 6000

**Үндсэн зорилтууд:** Эдгээр төслүүд нь хөдөөгийн иргэд, малчдыг шахмал түлш бэлтгэж сургах, малын баас, өтөг, бууцыг шахмал түлш, био бордоо хийх гэх мэт хэрэгтэй зүйлд нь ашиглаж чадвал нөөц бололцоо юм гэдгийг мэдрүүлэх, мод, бутыг түлшинд хэрэглэхээс татгалзах боломжийг хайх, нүүрсний хэрэглээг багасгах, өрхийн хэрэгцээнд ашиглаж байгаа нүүрсний нунтаг хаягдлыг дахин ашиглах боломжтой гэдгийг харуулах, шахмал түлшийг зөвхөн гар багажаар бус жижиг үйлдвэрлэлийн болон өөрсдөө хийсэн тоног төхөрөмж ашиглан хийх, энэ бүхнийг хийснээр байгаль орчны бохирдлыг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулах үндсэн зорилтуудыг агуулжээ.

**Үйл ажиллагааны тойм:** Төслүүдийн үйл ажиллагааг юуны өмнө аргал, хөрзөнгөө түлшинд илүү хэрэглэдэг Дундговь, Өвөрхангай зэрэг аймгуудын говь, хээрийн сумуудад төвлөрүүлж ажилласан байна. Хоёр төслөөр 600 гаруй шахмал түлшний гар багаж үйлдвэрлэж малчид, сумын төвийн хашаандаа малтай иргэдэд тарааж хэрэглэх заавар зөвлөгөө өгсөн байна. Мөн дараагийн хоёр төслөөр Дундговь аймгийн Сайнцагаан суманд малын өтөг, бууцыг нүүрсний нунтаг хаягдалтай хольж гар багажаар шахан түлш үйлдвэрлэж аймгийн төвийн айл өрхүүдийг түлшээр хангах ажил хийгдсэн. Шахмал түлш хийх энэ арга ажиллагаанд нутгийн 10 гаруй залуус суралцаж улирлын чанартай ажлын байртай болсон байна. Түүнчлэн шахмал түлш хийх, түүний хэрэглээний талаар мэдээлэл, суртчилгааны ажлууд аймгийн төв дээр хийгджээ. Ийнхүү шахмал түлшийг өрхийн хэмжээнд гар

багаж ашиглан хийхийн зэрэгцээ МОН/06/16, МОН/06/17 жижиг төслүүдээр Хятад улсаас зориулалтын тоног төхөөрөмж буюу шахагч машин оруулж ирэн Говь-Алтай аймгийн Алтай, Эрдэнэ сумдад ашиглах, Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд МОН/06/29 жижиг төслийн санхүүжилтээр цахилгаанаар ажилладаг 5 ширхэг шахагч машиныг иргэн Пүрэвжал бүтээж ашиглах зэргээр энэ ажлыг жижиг үйлдвэрлэлийн хэмжээнд хийх талаар санаачлага гарган ажилласан байна. Мөн МОН/13/17 жижиг төслөөр Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд үртсээр шахмал түлш хийхэд тодорхой дэмжлэг үзүүлсэн байна.

**Үр дүнгийн тойм:** Юуны өмнө говь, тал хээрийн бүсийн суманд олон айл өрхүүд хашаандаа шахмал түлш хийж өвлийнхөө түлшийг бэлддэг болоход тодорхой хувь нэмэр оруулсан гэдгийг тэмдэглэх



Дундговь аймгийн Сайнцагаан суманд шахмал түлш хийж байгаа нь

хэрэгтэй. Иргэд, малчид өөрсдөө нөөц, боломжоо ашиглан түлшээ бэлдэх болсон нь тэднийг дараагийн ээлжинд өрхийн ямар нэгэн үйлдвэрлэл явуулахад тус дөхөм үзүүлэхүйц алхам, туршлага болсон төдийгүй хөдөөд нэг төрлийн шинэ ажлын байр, орлогын эх үүсвэр нэмэгдэж байна гэж үзэж байна. Хол газраас тээвэрлэж авчирдаг, хөдөөгийн айл өрхүүд тэр бүр ашиглаад байх боломж хомс, үнэ ихтэй нүүрсний оронд энэхүү шахмал түлшийг хэрэглэснээр хөрөнгө мөнгө, цаг хугацааг мөн хэмнэж байгаагийн зэрэгцээ зарим сум суурин газрын ойролцоох малын баас, хөрзөнгийн хаягдал овоолгоос байгаль орчин үзүүлэх нөлөө тодорхой хэмжээгээр багассан байна. Түүнчлэн нүүрсний нунтгийг хог болгож хаялгүйгээр шахмал түлшний орц материал болгон ашиглаж болохоор болжээ. Энэхүү шахмал түлш нь манай улсын хувьд хямд төсөр аргаар үйлдвэрлэх боломжтой түлшний нэг төрөл бөгөөд цаашид хийц, орц найрлага, үйлдвэрлэл, хэрэглээний арга, техникийг улам боловсронгуй болгох, орон нутгийн засаг захиргаанаас энэ төрлийн шахмал түлшний олон талын ач холбогдлыг харгалзан үзэж шинэ ажлын байр гэдэг талаас нь давхар харж жижиг үйлдвэрлэл болгон хөгжүүлж хүрээг нь тэлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах нь зүйтэй байна. Эцэст нь тэмдэглэхэд малын өтөг, бууцыг хог хаягдал бус нөөц боломж гэж харах хүмүүсийн тоо нэлээд хэмжээгээр нэмэгдсэн байна.

## Арван нэг. НӨХӨРЛӨЛ, ИРГЭДИЙН ЭЗЭМШЛИЙН УСАН ТОЛИО

**Нөхөрлөлийн эзэмшлийн усан толио байгуулахыг дэмжих нь**

Байгалийн буюу бороо, цасны ус, жижиг гол, горхи, булаг, шандыг ашиглан жижиг усан толио байгуулж усыг хуримтлуулан ашиглах нь олон талын ач холбогдолтой юм. Манай орон гадаргын усаар төдийлөн баялаг бус бөгөөд ялангуяа Хэнтий, Хангай, Хөвсгөлийн уулсаас эх авсан гол горхи урсдаг нутаг дэвсгэрээс бусад орчинд гадаргын ус хомс билээ. Ийм нөхцөлд иргэд, нөхөрлөлүүд өөрсдийн хүчээр усан толио байгуулж ашигласнаар усгүйн улмаас ашиглаж чадахгүй байгаа бэлчээрийг ашиглах, сум, суурин газрын ойролцоох бэлчээрийг талхагдлаас хамгаалах, мал, бусад гэрийн тэжээвэр болон зэрлэг амьтдын усан хангамжийг сайжруулах, маш удаан хугацаанд нөхөн сэргээгддэг газрын доорхи усны нөөцийг хэмнэх, гүний усыг татах усны шахуурга ажиллуулахад зарцуулах түлш шатахуунаа хэмнэх, ингэснээр агаарт ялгаруулах хүлэмжийн хийг багасгаж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмрээ оруулах, төмс, хүнсний ногоо, нөхөрлөлийн жимсний цэцэрлэг зэрэг жижиг ногоон байгууламжуудыг услахад гадаргын усыг ашиглах боломж бүрдэнэ. Мөн усан толио бий болсноор тухайн орчны агаар чийгших, ургамлын нөмрөгт эерэгээр нөлөөлөх, улмаар ойр орчиндоо экологийн таатай нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй зарим тохиолдолд амралт зугаалгын орчинг бий болгох боломжтой юм.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дугаар хэсэгт “Хууль, гэрээнд заасан журмын дагуу иргэн өмчийн болон эзэмшлийн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газар дээрээ өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ургамал, ой мод, өсгөж үржүүлсэн амьтан болон хурын усыг хуримтлуулах замаар байгуулсан усан сан, нуур, цөөрмийг өмчилж болно” хэмээн заасан байдаг.

**Хэрэгжүүлсэн төслийн тоо:** 5

**Хамарсан нутаг дэвсгэр:** Төв аймгийн Сэргэлэн, Хэнтий аймгийн Биндэр сум

**ЖТХ-ийн санхүүжилт:** 55,493 ам. доллар

**Төсөл хэрэгжүүлсэн нөхөрлөлийн тоо:** 1

**Төсөл хэрэгжүүлсэн төрийн бус байгууллагын тоо:** 4

**Төсөл хэрэгжүүлэгчдээс гаргасан хөрөнгө:**

**-мөнгөн:** 14,258 ам. доллар

**-материаллаг:** 27,477 ам. доллар

**Үр ашиг хүртэгсдийн тоо:** 45 өрх

**Үндсэн зорилтууд:** Цас, борооны ус, жижиг гол, горхи, булаг, шандын усыг хуримтлуулж ашиглах замаар мал аж ахуй, газар тариаланд гадаргын усны эх үүсвэрийн ашиглалтыг нэмэгдүүлэх, усны эх үүсвэрээс алслагдсан бэлчээрийг ашиглах, тухайн усны эх үүсвэрээс орчны экосистемд үзүүлэх үйлчилгээний үр нөлөөг нэмэгдүүлэх, гүний ус ашиглах зардлыг хэмнэх, иргэдийн ахуй амьдралд тус дөхөм үзүүлэх, байгаль орчны нөхцлийг сайжруулах, жижиг хиймэл усан сан буюу усан толио барьж ашиглахын ач холбогдлыг нийтэд таниулахад хэрэгжүүлсэн төслүүдийн үндсэн зорилтууд оршино.

**Үйл ажиллагааны тойм:** Нутгийн иргэдийн ахуйн болон мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд ашиглах 5 усан толио байгуулсны дөрвийг нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт, нэгийг нь Хэнтий аймгийн Биндэр сумын нутагт барьсан байна. Эдгээр усан толионуудыг барихдаа тухайн орчинд бороо, цасны усны урсац бүрдэх байдал, далан босгоход тодорхой гүнтэй, аль болох өргөн толио үүсгэж болох хамгийн тохиромжтой газрыг тогтоож сонгох талаар судалгаа хийж орон нутгийн тухайн үеийн удирдлага болон ойр орчны малчид, иргэдтэй сайтар зөвлөлдсөний үндсэн дээр ажлыг гүйцэтгэсэн байна. Сэргэлэнд суманд барьсан усан толионуудын барилгын ажилд орчин үеийн техник тоног төхөөрөмж буюу газар ухагч, шороо ачигч, хүнд даацын машин ашигласан бол Биндэр суманд нутгийн иргэд өөрсдийн боломжийг ашиглан жижиг цементэн хавтангуудаар хана босгож элс шороогоор хучих байдлаар усан толиогоо барьсан байна. Усан толионы ёроолыг засаж тэгшилсэн бөгөөд далангийн шороон овоолгыг ус нэвтрүүлдэггүй зориулалтын

хар хальсаар бүрж шороогоор дээрээс нь нэмж хучсан байна. Далан бүрт илүүдэл усаа зайлуулах суваг гаргаж өгсөн бөгөөд Биндэр суманд барьсан усан толионы цементэн далангийн голын хэсэгт илүүдэл усыг гадагшлуулах сэтэрхий гаргаж өгсний дээр модон таглаатай тусгай нүх гаргаж доор нь мал услах онгоц байршуулж өгчээ. Мөн шороон далангуудын бөх баг байдлыг хангаж өгөхийн тулд чулуугаар хучих, далан дээр бургас тарих, зарим даланг торон хашаагаар хамгаалах ажлуудыг хийжээ.

**Үр дүнгийн тойм:** Юуны өмнө 40 гаруй малчин өрх гадаргын усны эх үүсвэрээр хангагдаж хавар, зун, намрын цагт мал усалгааны ил задгай эх үүсвэртэй болж худаг бараадан бууж тэр орчны газар бэлчээрийг талхалдаг байдлаасаа гарч чадсан байна. Ингэснээр худаг ажиллуулах хөдөлмөр, цаг, зардлаа хэмнэж бусад ажил, амралтдаа зарцуулах боломжтой болжээ. Усан толионууд нь мөн бэлчээр ашиглалтын хуваарьт ямар нэг байдлаар нааштай өөрчлөлт оруулсан гэж үзэж байгаа. Өмнө нь богино хугацаагаар ашиглаж байсан бэлчээрийг одоо урт хугацаагаар ашиглах боломжтой боллоо гэж зарим малчид ярьж байсан. Усан толионууд нь зөвхөн мал услахад зориулагдаад зогсохгүй орчныхоо экосистемд эерэг нөлөө үзүүлж зэрлэг амьтдын ундны эх үүсвэр, нүүдлийн шувуудын зусдаг газар болж байна. Тахилтын аманд баригдсан цуваа 2 усан толионы дэргэд нутгийн иргэд хүнсний



Хэнтий аймгийн Биндэр суманд нутгийн малчдын хийсэн усан толио

ногоо тарьж мод үржүүлгийн газар болон чацарганы жижиг плантаци байгуулан ажиллуулж байгаа нь цаашид ийм төрлийн арга хэмжээг боломжтой газруудад нь үргэлжлүүлэн хийвэл олон талын ач холбогдолтой байхыг харуулж байна.

## Арван хоёр. НӨХӨРЛӨЛИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ

### Иргэд, нөхөрлөлийг чадавхижуулах нь

Чадавхи бий болгох гэдэг нь аливаа хувь хүн эсвэл байгууллага өөрийн хариуцсан ажлаа хийж гүйцэтгэхэд шаардагдах ур чадвар, мэдлэгийг олж авах, сайжруулах, хадгалан үлдээх үйл явцыг хэлдэг байна. Иргэний нийгмийн хөгжил дөнгөж эхлэлийнхээ шатанд яваа манай улсын хувьд иргэд, хөдөлмөрчдөд чадавхи бий болгох, түүнийг хөгжүүлэх явдал онцгой ач холбогдолтой юм. Ялангуяа шинээр үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхлэхдээ элдэв саад бэрхшээлтэй тулгарч байгаа байгаль хамгаалах нөхөрлөлүүд, малчны бүлгүүд, төрийн бус байгууллагуудын хувьд чадавхийн асуудал онцгой ач холбогдолтой гэж хэлж болно. Тэдэнд шинээр сурч мэдэх зүйлс өдөр тутам тулгарч улмаар хэвийн ажиллах, хийж бүтээхэд нь саад тотгор болох нь бий. Шинэ нийгмийн харилцаанд шилжиж урьд өмнө хийж байгаагүй шинэ ажлуудыг хийж гүйцэтгэхэд шинээр байгуулагдсан байгаль хамгаалах нөхөрлөлүүдэд сурах зүйлс маш олон байсан нь тодорхой. Иймд тус Хөтөлбөрөөс танхимын болон талбайн сургалтууд явуулах, харилцан туршлага судлуулах, танилцах аялал хийх, нөхөрлөл хөгжлийн наадам, мэдлэгийн яармаг зохион байгуулах, ном, товхимол, төрөл бүрийн гарын авлагууд, видео танилцуулгууд, мэдээлэх хуудсууд гаргах, төсөл хэрэгжүүлэгчдийг нэгдсэн сүлжээнд хамруулж зохион байгуулалтад оруулах, нөхөрлөлийн мэдээллийн болон сургалтын төв байгуулахад дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг хийж иргэд, нөхөрлөл, малчдын бүлгүүдийг чадавхижуулахад ихээхэн хувь нэмэр оруулж чадсан байна.

**Хэрэгжүүлсэн төслийн тоо:** 24

**Хамарсан нутаг дэвсгэр:** Архангай, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Орхон, Өвөрхангай, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын зарим сумд

**ЖТХ-ийн санхүүжилт:** 322,301 ам. доллар

**Төсөл хэрэгжүүлсэн нөхөрлөлийн тоо:** 2

**Төсөл хэрэгжүүлсэн төрийн бус байгууллагын тоо:** 22

**Төсөл хэрэгжүүлэгчдээс гаргасан хөрөнгө:**

-**мөнгөн:** 52,246 ам. доллар

-**материаллаг:** 176,704 ам. доллар

**Бусад хандивлагчийн санхүүжилт:** 150,000 ам. доллар

**Үр ашиг хүртэгсдийн тоо:** 5000

**Үндсэн зорилтууд:** Шинэ нийгмийн харилцаа буюу зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэний дараа шинээр байгуулагдсан байгаль хамгаалах нөхөрлөлүүд, малчдын бүлгүүд, байгаль орчны төрийн бус байгууллагууд, хөдөөгийн иргэдийг байгаль орчныг хамгаалах арга ажиллагаанд сургаж дадлагажуулах, үйл ажиллагаагаа бие даан явуулах чадавхи бий болгож хөгжүүлэхэд эдгээр төслүүдийн үндсэн зорилтууд оршжээ.

**Үйл ажиллагааны тойм:** Манай улсад 2 зууны зааг буюу 1990-ээд оны сүүлч 2000-аад оны эхэн үеэс байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүд, түүний дотор хамтын оролцоотой ойн менежментийн нөхөрлөлүүд олноор байгуулагдаж эхэлсэн бөгөөд тэдний тоо өнөөдөр 1600-г даваад байна. Шинэ тутам байгуулагдсан нөхөрлөлүүдийг чадавхижуулах, хийх ажилд нь дэмжлэг үзүүлэхийн тулд юуны өмнө танхимын болон талбайн сургалтуудыг тодорхой сэдвүүдээр дэс дараатай хийж эхэлжээ. 10 гаруй жилийн хугацаанд 27 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 300 гаруй нөхөрлөл, малчны бүлгийн 1400 орчим гишүүдийг талбайн болон танхимын сургалтад хамруулжээ. Нөхөрлөлийн гишүүдэд харилцан туршлага судлах боломжийг олгох зорилгоор ижил төстэй үйл ажиллагаа явуулж байгаа 30 гаруй нөхөрлөл хоорондоо гишүүдээ харилцан айлчлуулж мэдлэг туршлагаа солилцсон нь чухал арга хэмжээ болсон байна. Мөн шинээр төсөлд хамрагдах нөхөрлөлүүдийн ахлагч нарыг үйл ажиллагаа нь жигдэрч амжилттай явагдаж байгаа нөхөрлөлүүдийн талбай, ажилтай танилцах аялалыг 4 удаа зохион байгуулсан байна. Монгол дахь НҮБ-ын бусад төрөлжсөн байгууллагуудтай хамтран 2006 онд Нөхөрлөл Хөгжлийн Наадмыг, 2012 онд нөхөрлөлүүдийн Мэдлэгийн Яармагийг Улаанбаатар хотод тус тус улсын хэмжээнд анх удаагаа зохион байгуулжээ. Иргэд нөхөрлөлийн байгаль орчны талаархи мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, тэргүүн туршлагыг

түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Мэдлэг, Туршлага, Амжилт”, “Багаас эхэлсэн бахдам амжилтууд”, “Зөгий сонирхогчдод өгөх зөвлөмж”, “Байгаль хамгаалах нөхөрлөлд холбогдох хууль тогтоомжийн эмхэтгэл”, “Төсөл хэрэгжүүлэгчдийн ололт амжилт, сургамжаас”, “Усны нөөцийг хуримтлуулах, хамгаалах технологи”, “Үр тарьц суулгац үйлдвэрлэгчдийн гарын авлага”, “Орон нутгийн байгаль орчны төрийн бус байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх гарын авлага”, “Загас үржүүлэх технологийн гарын авлага”, “Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөлийн гарын авлага”, “Ногоон хөгжил-шийдвэр гаргахад оролцох нутгийн иргэдэд зориулсан гарын авлага”, “Иргэдийн жимсний аж ахуйг хөгжүүлбэ”, “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хөдөөгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлбэ” зурагт хуудас гэх зэрэг нийт 170 гаруй ном, товхимол, гарын авлага, зурагт хуудас, төслийн тойм, судалгаа, заавар, зөвлөмж гаргасны дээр 30 гаруй теле нэвтрүүлэг, видео найруулал, бичлэг, хичээл, фото үзүүлбэрүүд бэлтгэж орон нутгийн иргэдэд хүргэж танилцуулжээ. Түүнчлэн 21,000 фото зураг бүхий фото сан бүрдүүлсэн байна. Төсөлд хамрагдсан иргэд, нөхөрлөлүүд, малчны бүлгүүдийг нэгдсэн сүлжээнд хамруулах, мэдээллээр байнга хангаж байхын тулд сүлжээ үүсгэн мэйл хаяг ашиглан мэдээлэл түгээж байгаа бөгөөд тэдний нэлээд хэсэг нь сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж “Хөгжилд Хүрэх Түншлэл” нэртэй төрийн бус байгууллага байгуулан хамтран ажиллахад нь, мөн Сэлэнгэ аймгийн Баянгол суманд “Байгаль” нэртэй нөхөрлөлүүдийн сургалтын төвийг, Хэнтий аймгийн Биндэр, Дархан-Уул аймгийн Орхон, Булган аймгийн Хутаг-Өндөр сумдад нөхөрлөл хөгжлийн төвийг байгуулахад нь тус тус зохих дэмжлэгүүдийг үзүүлсэн байна.

**Үр дүнгийн тойм:** Нөхөрлөл болон малчны бүлгүүдийг чадавхижуулах төслүүдийг хэрэгжүүлсний үр дүнд ойролцоо тооцоогоор хөдөөгийн 8000 орчим иргэн нэг болон хэд хэдэн төрлийн ажлыг хийж чаддаг болсон байна. Бүх өмч улсын байсан өмнөх нийгмээс зах зээлийн харилцаанд шилжих явцад тохиолдсон эдийн засгийн болон нийгмийн гүн гүнзгий хямралыг давах хүнд үеийг туулж байсан хөдөөгийн иргэдийн хувьд шинэ ажлын байр, шинэ орлогын эх үүсвэрүүд хэзээ хэзээнээс чухал шаардлагатай байсан бөгөөд тэдэнд тодорхой ажлуудыг хийж сурах мэдлэг олгож дадлага суулгаж өгсөн нь эдгээр төслүүдийн гол үр дүн гэж дүгнэж болохоор

байна. Хөтөлбөрт хамрагдсан хөдөөгийн иргэд өөрсдийн эзэмшлийн тарьц, суулгац үржүүлгийн газартай буюу энэ чиглэлээр өөрийн гэсэн өмчтэй болж төрөл бүрийн модыг хэрхэн тарих, арчлах, хүлэмж, усалгааны болон бусад техник, тоног төхөөрөмжүүдийг ашиглах мэдлэг, дадлага, туршлагатай болохоос эхлэн зөгий маллах, гар аргаар шахмал түлш үйлдвэрлэх, малын бууцаар био бордоо болон био нүүрс хийх, усан толио барих, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хөгжүүлэх зэрэг олон ажил үйлчилгээнүүдийг бие даан хийж гүйцэтгэж олон сайхан амжилтуудыг гаргаж, мэдлэг туршлагаа бусадтайгаа хуваалцаар байна.



2012 онд зохиогдсон Мэдлэгийн Яармагийн үзэсгэлэн-худалдааны танхимд

## Арван гурав. ХӨДӨӨГИЙН ИРГЭДИЙН АМЬЖИРГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

### Хөдөөгийн иргэдийн амьжиргааг байгаль хамгаалалтай уялдуулан дэмжих нь

Хөдөө орон нутагт явуулж байгаа байгаль орчныг хамгаалах аливаа үйл ажиллагааны үр өгөөж тухайн орчинд амьдарч байгаа иргэдийн амьжиргааны түвшнээс ихээхэн хамааралтай гэж хэлж болно. Ядуурал газар авч амьжиргааны түвшин доошлоход иргэд амь зуухын тулд байгаль руугаа дайрч довтлон хайр найргүй сүйтгэж байсныг 1990-ээд оны эхэн үед бид бүгд харж мэдэрсэн билээ. “Ядуурлын нөхцөлд байгаль хамгаалах талаар яриад ч нэмэргүй” хэмээн Энэтхэгийн Ерөнхий Сайд асан Индира Ганди нэгэнтээ хэлж байжээ. Иймд Жижиг Төслийн Хөтөлбөрийн зүгээс байгаль хамгаалах арга хэмжээг иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, тэдний орлогыг нэмэгдүүлэх, орлогын шинэ, нэмэлт эх үүсвэрүүд бий болгох зэрэг олон үйл ажиллагаануудтай харилцан уялдаатайгаар авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулснаар байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлжээ. Хэдийгээр иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, орлогыг нэмэгдүүлэх чиглэлд ердөө 14 төслийг төлөөлүүлэн авч үзсэн ч ерөнхийдөө 2003-2014 онуудад тус Хөтөлбөрөөс хэрэгжүүлсэн нийт 382 төслийн 70 гаруй хувь нь хөдөөгийн иргэд, байгаль хамгаалах нөхөрлөлийн болон малчны бүлгийн гишүүдийн амьдрал, ахуйд тодорхой хувь нэмэр оруулжээ.

**Хэрэгжүүлсэн төслийн тоо:** 14

**Хамарсан нутаг дэвсгэр:** Архангай, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Орхон, Өвөрхангай, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын зарим сумд

**ЖТХ-ийн санхүүжилт:** 127,071 ам. доллар

**Төсөл хэрэгжүүлсэн нөхөрлөлийн тоо:** 6

**Төсөл хэрэгжүүлсэн төрийн бус байгууллагын тоо:** 8

**Төсөл хэрэгжүүлэгчдээс гаргасан хөрөнгө:****-мөнгөн:** 38,687 ам. доллар**-материаллаг:** 91,970 ам. доллар**Үр ашиг хүртэгсдийн тоо:** 2000

**Үндсэн зорилтууд:** Байгаль хамгаалах арга хэмжээг ядуурлыг бууруулах, хөдөөгийн иргэдийн ахуй, амьдралын нөхцөлийг сайжруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэхтэй нягт уялдуулан хэрэгжүүлэхэд дээрхи төслүүдийн үндсэн зорилтууд оршиж байна.

**Үйл ажиллагааны тойм:** Ядуурлыг бууруулах, хөдөөгийн иргэдийн ахуй, амьдралын нөхцөлийг сайжруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн төслүүдэд юуны өмнө нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, төрөл бүрийн модны тарьц суулгац үржүүлж зах зээлд нийлүүлэх, ховор болон эмийн ургамал тариалах, ногоон бордуур ургамал тарьж малын тэжээл бэлтгэх, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, цацагт хяруул үржүүлэх, чацаргана, үхрийн нүд гэх мэт жимсний төгөл байгуулах, бэлчээр хашиж хамгаалан ургамлын үрийн болцыг гүйцээж ургацыг нэмэгдүүлэх замаар малын ашиг шимийг нэмэгдүүлэх, нөхөрлөлүүдийн дундын санд дэмжлэг үзүүлэх, бичил зээлийн сан бүрдүүлэх, ноос угаах, боловсруулах жижиг цех байгуулах, гэрийн мод болон гар урлалын зүйлс үйлдвэрлэх, нөхөрлөлийн хөгжлийн төв байгуулах зэрэг ажлуудыг нэрлэж байна.

**Үр дүнгийн тойм:** Өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн төслүүд өөр өөрсдийн чиглэлээр тодорхой үр дүнд хүрч байгаль хамгаалах нөхөрлөлийн гишүүд, иргэдийн амьдрал, ахуйд хувь нэмрээ оруулсаар байна. Төв аймгийн Баяндэлгэр, Өвөрхангай аймгийн Богд, Есөнзүйл, Арвайхээр, Бат-Өлзий, Булган аймгийн Рашаант, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Архангай аймгийн Тариат, Хэнтий аймгийн Дадал сумдад аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа жижиг баазууд жил бүр тодорхой ашигтай, үр дүнтэй ажиллаж ирсний дээр зарим нь компани болон өргөжиж үйл ажиллагаагаа тогтвортой сайн явуулж байна. Төрөл бүрийн модны суулгац үйлдвэрлэгчдийн тоо 40 гаруй болсон бөгөөд жилд дунджаар 3 сая орчим суулгац гаргаж байна. Эмийн болон ховор ургамал тарих сонирхолтой иргэд, нөхөрлөлийн тоо төдийлөн олон бус байгаа ч аажмаар нэмэгдэж байна. Бэлчээр хамгаалах, хөрсний үржил шимийг сайжруулах, талхагдлыг багасгахад нөлөөлөх зорилгоор

ногоон бордуур ургамал тариалахад дэмжлэг үзүүлсэн нь үр дүнгээ өгч өвлийн улиралд чанар сайтай тэжээлээр малаа тэжээж сүүний гарцыг бууруулахгүй байх боломжийг бүрдүүлж байгаагаараа иргэдийн амьдралд тус дөхөм үзүүлж байна. Нөхөрлөлийн эзэмшлийн жимсний талбай байгуулах ажилд нэлээд анхаарч ач холбогдол өгч ажилласны дүнд олон нөхөрлөлүүд өөрийн гэсэн чацаргана, үхрийн нүдний жимсний цэцэрлэг, талбайтай болж жил бүр тодорхой хэмжээний жимс хураан авч өрхийн орлогоо нэмэгдүүлсээр байна. Жимсний цэцэрлэгээс жилд дунджаар 500-800 кг чацаргана, 150-200 кг үхрийн нүд жимс хурааж байгаа мэдээтэй байгаа ч зарим газар, жишээ нь Дархан Ногоон Арал ТББ-ын талбайгаас жилд 5 тонн хүртэл чацаргана хураан авч байна. Нэгж талбайн өгөөжийг сайжруулах, бүтээгдэхүүний гарц, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 80 гаруй хүлэмжийг нөхөрлөл, малчдын бүлгүүдэд нийлүүлсэн нь суулгац үржүүлэх, хүнсний ногоо тарьж орлогоо нэмэгдүүлэх боломж олгож байна. Дөрвөн суманд нөхөрлөлийн хөгжлийн төв байгуулахад дэмжлэг үзүүлсэн нь нөхөрлөлүүд зохион байгуулалтад орж ажил төрлөө уялдуулан хамтарч ажиллахад тустай арга хэмжээ болсон байна.



Эрдэнэшишийн дарш бэлтгэж байгаа нь. Сэлэнгэ, Алтанбулаг

## ЗАРИМ ТЭРГҮҮНИЙ НӨХӨРЛӨЛИЙН АХЛАГЧДЫН АЖЛЫН АМЖИЛТ, ТУРШЛАГААС

### Ажлын төлөө төрсөн хүн



Сэлэнгэ аймгийн Баянгол сумын “Хараагийн хишиг” нөхөрлөлийн ахлагч **П.Дагвадорж**

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын “Хараагийн Хишиг” нөхөрлөлийн ахлагч П.Дагвадорж гуай Архангай аймгийн Өгийнуур сумын уугуул боловч Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Жимс жимсгэний станциас анхны ажил, амьдралын гараагаа эхэлжээ. Тэрээр тухайн үеийн жимс жимсгэнэ, зөгийн аж ахуйн салбарын эрдэмтэд, судлаачдаас ёстой л өөрийн савны хэмжээгээр мэдлэг, туршлага дүүргэн авч хөдөө аж ахуйн бүхий л үйлдвэрлэлд гар биеэрээ нэр хүндтэйгээр оролцон бүтээж явсаар өдийг хүрчээ. П.Дагвадорж гуай

1976 онд улс, аймагтаа анх цоо шинээр зөгийн товарын ферм байгуулан ажиллаж байснаар тухайн үедээ зөгийн аж ахуйн өнгийг тодорхойлогсдын нэг болж явжээ. Хэн нэгний хийсэн ажил барагтай л бол санаанд нь таардаггүй тэрээр голж шилэхийн тулд биш юмыг сайн хийлгэж сургах гэсэндээ санасан бодсоноо шулуунхан хэлчихдэг нэгэн.

Нийгэм солигдож ёстой л бум бужигнаж, түм түжигнэж эхэлсэн тэр үед П.Дагвадорж гуай маань нуруундаа хүнд бэртэл гэмтэл авч хэвтэрт орсон ч угийн зүгээр сууж чаддаггүй хөдөлмөрч зангийнхаа хүчинд хөл дээрээ дахин босчээ. 2005 онд ДДБОС-гийн ЖТХ-т хамрагдаж хоосон тал дээр Монголдоо бараг хамгийн анхны гэж хэлж болохоор нөхөрлөлийн эзэмшлийн жимсний цэцэрлэг байгуулах ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн юм. Сурсан бүхэн хүнд хэрэг болдог болохоор нөхөрлөлийн цэцэрлэгээ түшиглэн мод үржүүлэх, жимс, ногооны хамгаалалтын ойн зурвас байгуулах, мод, хүнсний ногооныхоо нэр төрлийг олшруулах, зөгий үржүүлэх зэрэг олон ажлуудыг дэс дараалан хийхийн зэрэгцээ хөрш зэргэлдээх иргэд,

нөхөрлөлүүддээ зааж сурган зөвлөсөөр иржээ. Үүний зэрэгцээ сумын төвийг ногооруулах, Хараа голын бургасыг хамгаалах, нөхөн сэргээх талаар санаачлага гарган иргэд, сумын удирдлага, олон улсын төсөл, хөтөлбөрийн анхаарлыг хандуулж ажилласнаар сумын төвд нийлбэр дүнгээр 76 га талбайд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд жимс жимсгэнэ, мод тарьж ургуулан 121 өрх хашаандаа 7356 ширхэг жимсний мод, буттай болж ашиг шимийг нь хүртэж байна. Түүнчлэн Баянгол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Улсын тэргүүний ногоон сум болох шийдвэр гарган амжилттай хэрэгжүүлж байгаа нь ч зөгийн гэх П.Дагвадорж гуайн хөдөлмөр зүтгэлтэй холбоотой.

Бурханлаг ариун үйлс болох байгаль хамгаалах, нөхөн сэргээх, мод тарих ажлыг хийж насаараа зөгийчин, цэцэрлэгч яваа энэ эгэл хүний хөдөлмөрийг төр засаг өндрөөр үнэлэж “Алтан гадас” одонгоор энгэрийг нь мялаасны дээр НҮБХХ Экваторын шагналаа хүртээжээ.

### Сэргээхээр шийдсэн гэр бүл



Хэнтий аймгийн Дадал сумын “Сэргээхүй” нөхөрлөлийн ахлагч **Г.Доржсүрэн**

“Сэргээхүй” нөхөрлөл нь сэргээхээр шийдсэн гэр бүлийнх. Эхнэр нь өвчтөнд амбулаторийн үзлэг, эмчилгээ хийж хүнийг сэргээдэг бол нөхөр нь мод үржүүлэг, жимс жимсгэний аж ахуй эрхэлж байгалийг сэргээнэ. Сумын Засаг даргын албыг хашиж байсан Г.Доржсүрэн гуай гавъяаныхаа амралтад гарангуутаа л дараагийнхаа ажилд шамдан оржээ. Ажлаа ДДБОС-гийн ЖТХ-ийн дэмжлэгээр эхэлж Цээнэтэй хэмээх газар 2.5 га газарт чацаргана тарьж сумандаа анхны томоохон жимсний талбай

байгуулсны зэрэгцээ хашаандаа өрхийн жимсний аж ахуйг хөгжүүлж эхэлжээ. Мөн энэ ажлынхаа хажуугаар сумынхаа 10 булгийг хашиж тохижуулан хамгаалсан байна. “Байгалийн эм” нөхөрлөлтэй хамтран нэн ховор ургамал болох Цагаан цээнийг хамгаалж эмийн ховор ургамал дэрэвгэр жиргэрүүг тарималжуулжээ. 2007-2008 онуудад 10 га газарт ногоон тэжээл тарьж хөрсний үржил шимийг сайжруулах, бэлчээрийн талхагдлыг бууруулахад ихээхэн хувь нэмэртэй болохыг орон нутагтаа туршиж тогтоосон байна. 2009 оноос Хэнтий аймгийн МСҮТ болон Дорнод аймгийн Политехник коллежтой гэрээтэй ажиллан байгаль экологи цэцэрлэгжүүлэлтийн ангийн оюутнуудыг авч дадлагажуулж байна. Өнгөрсөн хугацаанд нийтдээ 60 гаруй айл, 6 байгууллагыг жимсний болон чимэглэлийн модтой болгож 3 удаа сургалт зохион байгуулжээ. 2014 онд БОНХЯ-аас нутгийн ургамлыг тарих тусгай зөвшөөрлийг авсан. 2009 оноос гадаадын үүргэвчтэй аялагчдыг авдаг болсон ба зуны цагт дунджаар 30 орчим хүнийг түүхийн дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газраар аялуулдаг. Бараг бүх тивээс жуулчин авсан бөгөөд түүний товч танилцуулга япон, англи, франц, герман, хятад, итали зэрэг хэл дээр гарчээ. Жил бүр шар хуайс, гүйлс, алтан гагнуур, дэрэвгэр жиргэрүү, мойл, үрэл, голт бор, сараана, долоогого зэргийн үрийг бага хэмжээгээр түүж зах зээлд гаргана. Тарьсан зарим эмийн ургамлаа Монос, АПУ компаниудад, чацаргана жимсийг сумынхаа сургууль, цэцэрлэг, хүн эмнэлгээс гадна аймгийн Уламжлалт эмнэлэг, 2 дугаар цэцэрлэг, 1 дүгээр арван жилийн сургуульд гээд жилдээ 600 гаруй кг-ийг нийлүүлдэг. Сумын аварга ногоочин, жимсчин зэрэг өргөмжлөлийг 5 удаа хүртсэн. 2012 оны их түймрээр 3000 гаруй чацарганы модоо шатаалгаж хохирсон бол дараа нь энэ хохирлоо нөхөж 4 га газарт жимсний цэцэрлэгтэй болоод байгаа. Сүүлийн 2 жилд чийгийн улаан хорхой үржүүлж био ялзмаг хийж био нүүрс гаргаж авах талаар ажиллаж байна.

Төр засгийн хайр ивээл хүртэж Алтан гадас одон, Хөдөлмөрийн хүндэт медаль, Засгийн газрын жуух болон ойн медалиуд, Ардын боловсролын тэргүүний ажилтан, Ард түмний гавьяат багш цол, Ахмад багш нарын холбооны Багшийн гавьяа одон зэрэг олон шагналын эзэн болжээ.

## Ажилсаг гэр бүл



Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын “Баянчацаргана” нөхөрлөлийн ахлагч Д.Довдондэмбэрэл гэргийн хамт.

“Баянчацаргана” нөхөрлөл ойг нөхөн сэргээх, хамгаалах зорилгоор Сэлэнгэ аймгийн Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн санаачлагаар анх 2004 оны 12 дугаар сард Алтанбулаг сумын 3 дугаар багийн нутагт Баянбулаг хэмээх газар 6 өрхийн 18 гишүүнтэйгээр байгуулагдсан юм гэж яриагаа эхэлсэн нөхөрлөлийн ахлагч Д. Довдондэмбэрэл ийн өгүүлж байна.

Өнгөрсөн хугацаанд нөхөрлөлийн гишүүдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааны түвшинг дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалахад орчны бүсийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, бэлчээрийг зүй зохистой ашиглах, хөрсний элэгдлийг бууруулах, булгийн эхийн ундаргыг хамгаалах, жимс, хүнсний ногоо тариалах, модлог ургамлын тарьц, суулгац үржүүлж төсөл, хөтөлбөрт хамрагдан нөхөрлөлийн чадавхийг дээшлүүлэхэд анхаарч ажиллаж ирлээ. Манай нөхөрлөл 2007 онд ДДБОС-гийн ЖТХ-ийн санхүүжилтээр “Эх ундарга” нэртэй төсөл хэрэгжүүлж 3 га газрыг элсний нүүдлээс хашаажуулан хамгаалж, тухайн орчинд нь зонхилох төрлийн шилмүүст модоор ойжуулалт хийснээр бидний хамтын ажиллагаа эхэлсэн юм. Энэ ажлын үр дүнд элсний нүүлт зогсож, хашаагүй газартай харьцуулахад ургамлын нөмрөгийн биомасс эрс ихсэж, үржил шимтэй хөрс үүсэх үйл явц ажиглагдаж эхэлсэн. Үүний зэрэгцээ бид мод үржүүлэг, ойжуулалт, мал аж ахуй, хүнсний ногоо болон малын тэжээл тариалах, зөгий үржүүлэх зэргээр үйл ажиллагаагаа тус Хөтөлбөрийн дэмжлэгээр улам

өргөжүүлж ажиллаж байна. Тус Хөтөлбөртэй хамтран ажилласнаар хэд хэдэн сургалтад хамрагдаж байгаль орчныг хамгаалахтай холбогдсон аж ахуйн үйл ажиллагаандаа багагүй туршлага хуримтлуулсан төдийгүй малчдын маань нийгмийн идэвхи сайжирч, амьжиргааны шинэ эх үүсвэртэй болж улмаар өрхийн орлого нь нэмэгдэж эрхэлж буй ажилдаа мэргэшиж, туршлагажсаар байна.

“Баянчацаргана” нөхөрлөл маань жимсний жижиг аж ахуй хөгжүүлж үхрийн нүдний 500 бут, чацарганы 3000 бут, бөөрөлзгөнө болон алимны 50 бутыг тарьж ургуулсан. Одоогоор жилд 1,5 тонн чацаргана, 800 кг үхрийн нүд, 200 кг бөөрөлзгөнө болон алим хураан авч байгаа бөгөөд ургашын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байна. Мод үржүүлгийн чиглэлээр монгол оронд зонхилон ургадаг навчит болон шилмүүст модны тарьц суулгацыг 1 га газарт үржүүлж жил бүр борлуулалтанд гаргахаас гадна ойжуулалтын ажлыг 470 га талбайд хийж улсын санд хүлээлгэн өгсөн нь нөхөрлөлийн гишүүдийн идэвхи оролцоог нэмэгдүүлж цаашид үйл ажиллагаагаа улам эрчимжүүлэх зорилготой байна. Бидний энэ үйл ажиллагаанаас туршлага судлахаар Увс, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөлийн Алтай Саяны төсөл хэрэгжүүлэгчид, мөн Дархан-Уул аймгийн Дэлхийн зөн олон улсын байгууллагын төсөл хэрэгжүүлэгчид ирж Тужийн нарсны орчны бүсийн иргэдэд хамгаалалтын захиргаатай хамтран үзүүлэх сургалтыг зохион байгуулж байв. Мөн Тужийн нарсны хамгаалалтын захиргаатай хамтран малчдын экологийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг 5 удаа зохион байгуулж тухайн цаг үеийн байдал болон хууль бус үйл ажиллагаа, зөрчлийг мэдээлдэг журам тогтоосон.

Бидний үйл ажиллагаа ДДБОС-гийн ЖТХ-тэй салшгүй холбоотой бөгөөд үүсгэн байгуулагдсан цагаас хойш тасралтгүй дэмжиж, үр дүнд хүрэхэд гүүр болж өгсөнд манай нөхөрлөлийн хамт олны зүгээс талархаж байдаг. Бидний ажлын үр дүнг үнэлж Алтан гадас одон, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын цом, НҮБХХ-ийн Экваторын шагнал, Австри улсын “Энержи Глоб” шагнал, Алтанбулаг сумын “Алтан намар” тэргүүн байрын шагналуудыг хүртээсэн юм.

## ХӨДӨЛМӨРИЙГ АМТАЛЖ ЧАДСАН ЭРХЭМТЭЙ ХИЙСЭН ТОВЧ ЯРИЛЦЛАГА



Сэлэнгэ аймгийн  
Сүхбаатар  
сумын “Батдэм”  
нөхөрлөлийн ахлагч  
Г.Лувсанням

**-Танд юуны өмнө төрийн өндөр шагнал Алтангадас одонгоор энгэрээ мялаасанд баяр хүргэе.**

-Баярлалаа.

**-Та “Батдэм” нөхөрлөлийнхөө үйл ажиллагааны талаар бидэнд танилцуулна уу?**

-За “Батдэм” нөхөрлөл анх 1998 онд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 5 дугаар багт барилгын жижиг модон материал бэлтгэх, хүнсний ногоо тариалах, хадлан тэжээл бэлтгэх чиглэлээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн юм. 2003 оноос байгаль, цаг агаарын өөрчлөлт, цөлжилт, дулаарал буурахгүй байгаад санаа зовж байгалийн нөхөн сэргээлтэд хувь нэмрээ оруулах зорилгоор Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын Их Цагаан гэдэг газарт талхлагдсан бэлчээр бүхий 5 га газрыг хашиж хамгаалалтандаа авснаар миний байгаль хамгаалах ажил эхэлсэндээ. Ингээд удалгүй ДДБОС-гийн ЖТХ-т хамрагдан үйл ажиллагаагаа өргөтгөж эхэлсэн. 2008 оноос Сэлэнгэ аймгийн Орхон, Орхонтуул, Найрамдал, Зүүнбүрэн, Баруунбүрэн, Зүүнхараа, Сүхбаатар сумын цагдаагийн газар, төмөр зам, цэцэрлэг, сургуулиуд, Булган аймгийн Хутаг-Өндөр сум, Өвөрхангай, Орхон аймгууд, Улаанбаатар хотын төмөр зам, Гамшигтай тэмцэх газар зэрэг аймаг, хот, албан байгууллагуудтай холбоо тогтоон үр суулгац нийлүүлэн жимс жимсгэнэ тариалах, ногоон байгууламж бий болгох ажлуудыг хийж ажлын маань хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдсээр байна. Төслөө амжилттай хэрэгжүүлсэний үр дүнд 2009 онд ДДБОС-гийн ЖТХ-т Зөгий үржүүлэх чиглэлээр дахин хамрагдаж үйл ажиллагаа маань улам өргөжин тэлсээр байна. Өөрийн талбайд тарьсан үхрийн нүд, улаалзгана, алим, бөөрөлзгөнө, өрөл, монос, чацаргана зэрэг

жимсний моднуудаасаа жил бүр тодорхой хэмжээний үр, жимс хурааж чачарганы тос, жүүс зэрэг экологийн цэвэр бүтээгдэхүүнүүд гаргаж хүнсэндээ хэрэглэж байна. Нөхөрлөл маань ойрын хугацаанд мэргэжлийн байгууллага болох зорилт тавин 1 хүнийг экологи, байгаль хамгааллын чиглэлээр Хөдөө Аж Ахуйн Их Сургуульд суралцуулан мэргэжлийн боловсон хүчинтэй болж байгаадаа.

#### **-Жижиг төслийн үр дүн ямар байв даа?**

-2006 онд анх ДДБОС-гийн ЖТХ-т хандан “Загас үржүүлэг-Жимс жимсгэнэ” нэртэй төсөлдөө санхүүжилт авч Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Бор гүвээний нутаг дэвсгэр, мөн Зүүнбүрэн суманд орших Хөшөөтэй нуурын орчимд төслөө хэрэгжүүлсэн юм. Цаг агаар өөрчлөгдөж, цөлжилт, дулаарал эрчимтэй явагдаж байгаа өнөө үед бидний хийх ёстой ажлууд олон бий. Тэдгээрийн дотроос энэ төслөөр хийсэн гол ажил Хөшөөт нуурыг иргэдийн хамгаалалтад авч тэнд загасны үржил өсөлтөд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаануудыг явуулж эхэлсэн. Мөн жимс, жимсгэнэ тарих, гоёлын болон бусад модны суулгац үржүүлэх ажлыг эхэлснээр чачаргана, үхрийн нүд, тэхийн шээг, нохойн хошуу, монос, улиас, хайлаас, шархуайс, агч, говийн хүрэн сухай, бургас, балтхаргана, өрөл, алимны мод зэрэг 10 гаруй нэр төрлийн мод бүхий нөхөрлөлийн цэцэрлэг байгуулж, хэд хэдэн төрлийн модны суулгац үржүүлж айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд жил бүр нийлүүлэн тариулж байна. 2008 оноос өрх толгойлсон эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настан иргэдтэй 10 гаруй өрх айлд жимс, жимсгэний суулгац, хүнсний ногооны үрийг үнэ төлбөргүй өгч тариулсан нь ихээхэн үр дүнд хүрч түрүүчийн суулгацууд нь үр жимсээ өгч эхэлсэн байгаа. Мөн төсөлд хамрагдсанаар 10 хүнийг ажлын байраар хангаж тодорхой хэмжээний орлоготой болгосон. Одоо жилд дунджаар 15,000-25,000 суулгац үйлдвэрлэж байна. Мөн зөгий үржүүлэх ажилд өөрөө болон үр хүүхдүүдээ дадлагажуулж байна даа.

#### **-Төслийн нөлөөгөөр шинээр сэдэж хэрэгжүүлж байгаа ажил байхуу?**

-Байнаа. Ер нь хүн ажиллаад л байвал хийх юм мундахгүй. 2012 оноос галуу, цацагт хяруул үржүүлж байгаа. Арга эвийг нь олбол ашигтай бололтой.

### **“Хөгжилд Хүрэх Түншлэл” төрийн бус байгууллагыг танилцуулах нь**

ДДБОС-гийн ЖТХ-т хамрагдан төсөл хэрэгжүүлж амжилттай ажилласан 54 нөхөрлөл, төрийн бус байгууллагууд анх сайн дурын үндсэн дээр **“Ногоон ирээдүйг хамтын түншлэлээр байгуулцгаая”** уриан дор эвлэлдэн нэгдэж “Хөгжилд Хүрэх Түншлэл” нэртэй төрийн байгууллагыг 2014 онд байгуулан мэдлэг, мэдээлэл, туршлагаа хуваалцах, харилцан туслалцах хэлбэрээр хамтран ажиллаж байгаагийн зэрэгцээ Сэлэнгэ аймгийн Баянгол суманд “Байгаль” нэртэй нөхөрлөлүүдийн сургалт-мэдээллийн төвийг ажиллуулж нөхөрлөлийн гишүүдээ чадавхижуулахад онцгой анхааран амжилттай ажиллаж байна.


### **“Хөгжилд Хүрэх Түншлэл” төрийн бус байгууллага**



### **Ногоон ирээдүйг хамтын түншлэлээр байгуулцгаая**

Бидний зорилго – Байгаль орчинд хор хөнөөлгүй арга туршлагыг ашиглах замаар нөхөрлөлүүд өөрсдийн орлогын нэмэлт эх үүсвэрийг бий болгох, нөхөрлөлүүдийг хамтран ажиллаж, хамтдаа түншлэн хөгжихөд дэмжлэг үзүүлнэ.

**Бүтэц, зохион байгуулалт**



**Байгууллагын засаглалын чадавхи**



**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ**

Нэг. Байгаль хамгаалал, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах

- Цөлжилттэй тэмцэх
- Газрын элэгдэл, эвдрэлтэй тэмцэх
- Ойн санг хамгаалах
- Бэлчээр, биологийн төрөл зүйлийг хамгаалах
- Байгалийн усны эх үүсвэрийг хамгаалах
- Байгалийн гамшигтай тэмцэх

Хоёр. Байгальд хор хөнөөлгүй арга ажиллагаагаар орлогоо нэмэгдүүлэх

- Мод, бутны палантаци, үржүүлэг
- Үр,суулгац бэлтгэх
- Чацаргана, нэрс, алим, чавга, интоор болон бусад жимс, жимсний аж ахуй
- Зөгий үржүүлэг
- Загас үржүүлэг
- Хотын болон өрхийн чимэглэлийн мод, бут, сөөг тариалалт
- Бүтээгдэхүүнээ цаг, зав, хөрөнгө хэмнэсэн интернэт худалдаагаар худалдаалах
- Жилд нэг удаа олсон орлогоосоо гишүүнчлэлийн татвараа төлөх

Гурав. Байгууллагын тогтвортой байдлыг хангах, дотоод засаглалыг бэхжүүлэх, хамтын бүтээн байгуулалт

- Гишүүдэд Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа, санхүү, гишүүнчлэлийн татварын бүрдэлт, зарцуулалт нээлттэй, ил тод байх
- Гишүүдийг чадавхижуулах, ногоон хөгжлийн менежмент, цахим харилцааг нэвтрүүлэх, гадаад, дотоодын туршлага судлах аялал,үзэсгэлэнд хамруулах
- Гадаад, дотоодын байгууллагуудаас санхүүгийн нэмэлт эх үүсвэр олох
- Төрийн болон төрийн бус байгууллага, Олон Улсын хөгжлийн байгууллагуудтай хамтран ажиллах
- Байгууллага болон хувь хүмүүсийн ажиллах, амьдрах орчныг сайжруулах **НОГООН БАЙГУУЛАМЖ** бий болгох гэрээт ажлыг хийж гүйцэтгэх.



### **Эргэх холбоо:**

**Хөгжилд Хүрэх Түншлэл ТББ**

Удирдах зөвлөл утас: 99232534

Зохицуулах Алба утас: 95092238

И-мэйл: [community.sgp@gmail.com](mailto:community.sgp@gmail.com)

Facebook: Хөгжилд Хүрэх Түншлэл

### **ДДБОС-гийн ЖТХ-ийн фото зургийн цомгоос**

- Нэг. Суулгац үржүүлэх, мод тарих
- Хоёр. Нөхөрлөлийн болон ТББ-ын эзэмшлийн жимсний цэцэрлэгүүд
- Гурав. Иргэд, нөхөрлөлийн зөгийн аж ахуй
- Дөрөв. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал
- Тав. Хамтын оролцоотой ойн менежмент
- Зургаа. Экосистем болон элэгдсэн газрын нөхөн сэргээлт
- Долоо. Орон нутагт хэрэглэгдэх арга техникүүд
- Найм. Загас хамгаалал
- Ес. Ховор болон эмийн ургамлыг тарималжуулах
- Арав. Шахмал түлш
- Арван нэг. Нөхөрлөл, иргэдийн эзэмшлийн усан толио
- Арван хоёр. Нөхөрлөлийг чадавхижуулах
- Арван гурав. Иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, орлогыг нэмэгдүүлэх
- Арван дөрөв. Хөтөлбөрийн үйл ажиллагаанаас

### 1. Суулгац үржүүлэх, мод тарих



















## 2. Нөхөрлөлийн болон ТББ-ын эзэмшлийн жимсний цэцэрлгүүд











### 3. Зөгийн аж ахуйг хөгжүүлэх









#### 4. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал








5. Хамтын оролцоотой ойн менежмент







Нэг алхам төслийн хүрээнд хийгдэх ажлын план зураг



6. Экосистем болон газар, хөрсний нөхөн сэргээлт

















7. Орон нутагт хэрэглэх арга техникүүд







## 8. Загас хамгаалал





9. Эмийн болон ховор ургамлыг, нөхөн сэргээх













11. Нөхөрлөл, иргэдийн эзэмшлийн усан толио





## 12. Нөхөрлөлийг чадавхжуулах













### 13. Иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, орлогыг нэмэгдүүлэх













## 14. Хөтөлбөрийн үйл ажиллагаанаас







#### ХАЯГ:

Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн Жижиг Төслийн Хөтөлбөр  
НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, НҮБ-ын байр, НҮБ-ын гудамж-14,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14201, Монгол улс  
Утас: 976 (11) 327585 ext-1140, 70112883

Цахим шуудан: [ganbaatar.bandt@undp.org](mailto:ganbaatar.bandt@undp.org)  
[narangarav.gankhuyag@undp.org](mailto:narangarav.gankhuyag@undp.org)